

Улс төр

БАЙР СУУРЬ

Ц.Гомбосүрэн: Зөвлөлдөх санал асуулга удаан үргэлжилнэ

Эхлээд
жижиг сажиг
өөрчлөлт хийх нь
зүйтэй

Б.Гандолгор
@gandolgorZGM

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах Зөвлөлдөх зөвлөл байгуулсан билээ. Тус зөвлөлийн Ажлын хэсгийн гишүүн, Гадаад хэргийн сайд асан Ц.Гомбосүрэнтэй ярилцлаа.

-Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөлдөх санал асуулга явуулахаар боллоо. Энэ хэр ач холбогдолтой зүйл вэ. Энэ талаар байр суурна илэрхийлнэ үү?

-Үндсэн хуулийн зарим заалтыг засаж тодруулах гэсэн үзэл санаа сүүлийн жилүүдэд түгээмэл ажиглагдах болсон. Тэгэхээр ард түмний олонх нь ямар асуудлаар өөрчлөх саналтай байгааг иргэдийн төлөөлөл болох хэсэг хүнээс асууж, санаа оноог нь цуглуулах хэрэгтэй гэсэн санал гарсан. Зөвлөлдөх ардчиллын зарчмаар иргэдийн санаа оноог сонсдог ажил явагддаг болсон байна. Жишээлбэл, АНУ-ын Стэнфордын их сургуулийн профессор Жэймс С.Фишкин дэлхийн 20 гаруй улсад олон нийтгээс санал асуулга авах замаар асуудлыг шийдэх арга хэмжээ зохион байгуулсан байдаг. Манай улсад өнгөрсөн жил ирж Улаанбаатарт юу тулгамдаж байгаа, түүний эрэмбэ дараалал ямар байна гэдгийг зөвлөлдөх асуулгын зарчмаар судалсан юм билээ. Түүний энэ аргыг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ашиглахаар шийдсэн юм. Ингээд урьдчилсан байдлаар санаа оноо цуглуулахад зөвлөлдөх санал асуулгын арга барилыг хэрэглэхээр болсон. Үүнээс өмнө УИХ-аас Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийг баталсан юм байна. Энэ хуулийн заалтын дагуу гадаадад төлөвшсөн аргаар Үндсэн хуульд нэмэлт,



Б.Ганбаяр / ЗГМӨ

өөрчлөлт оруулахаар асуулга зохион байгуулах гэж байна. Түүврийн аргаар сонгогдсон хүмүүсийн санаа оноог Зөвлөлдөх зөвлөмөөр нэгтгээд УИХ-д өргөн мэдүүлэх юм. Зөвлөлдөх зөвлөл Н.Жанцанноров, Д.Ламжав нараар ахлуулсан найман хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлсэн. **“Тэгэхээр Зөвлөлдөх зөвлөл иргэдийн санаа оноог эцсийн байдлаар нэгтгэнэ гэсэн үг үү?”**

-Статистикийн үндэсний хорооноос санаандгүй түүврийн аргаар сонгосон 1500 хүний

саналыг энэ зөвлөл нэгтгэх юм. Энэ 1500 хүн бол зориудын судалгаа, мэдээлэлгүй өөрсдийн хар ухаанаар асуултад хариулна гэсэн үг. Тэднээс 750-ыг нь Улаанбаатарт цуглуулаад зургаан сэдвээр хэлэлцүүлэг явуулна. Эдгээр сэдвийг дотор нь нарийвчлан задалсан байгаа. Хэлэлцүүлэгт оролцсон 750 хүнд нарийн тодорхой мэдээлэл өгч, ойлголттой болгоно. Үүний дараа дахин 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэсэгчлэн хувааж, нарийн нягталж ярилцах юм. Эцэст нь бүлгүүд саналаа нэгтгээд 750 хүнийхээ бүрэлдэхүүнтэйгээр дахин хуралдаж санаа оноогоо хэлэлцэнэ. Үүний дараа дахиад санал хураалт явуулж байгаад Зөвлөлдөх зөвлөл тодорхой асуудлуудыг нэгтгэж, ийм зураглал харагдаж байна гэсэн

дүгнэлтээ гаргана. Эцсийн зөвлөмжийг бид гаргаж УИХ-д өргөн барина. Өргөн барьсан зөвлөмжийн дагуу УИХ Үндсэн хуульд ямар өөрчлөлт оруулахыг шийдэх томоохон комисс байгуулж, бүх нийтийг хамарсан санал асуулга явуулах байх. Дараа нь асуудлыг шийдэх замдаа орно доо. Их нарийн шат дараалалтай ажил болно гэсэн үг.

“Таны ярианаас анзаарахад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажил цаг хугацаа их шаардсан ажил болох нь. Эцсийн мөчид ямар үр дүн гарах бол. Өөрчлөхөөр тусгасан асуудлыг харахад Ерөнхий сайдад илүү эрх мэдэл олгох гээд байна гэсэн шүүмжлэлийг зарим хүн хэлдэг юм билээ?”

-Зарим хүн шүүмжлэх тал байна. Гэхдээ эцсийн дүнд том хэмжээний өөрчлөлт хийх дүн

гарахгүй ч байж магадгүй шүү дээ. Ерөнхийлөгчийн засаглалтай байх ёстой, эсвэл парламентын хоёр танхимтай байх нь зүйтэй гээд ард түмний санал ямар ч гарч болзошгүй. Бид бол ард түмний гаргасан зураглалыг л нэгтгэнэ. Ерөнхий сайдын эрх мэдлийг өргөтгөх, орон нутгийн засаг захиргааны нэгжийг шинэчлэх гээд олонхын санал Үндсэн хуулийн суурь зарчмыг эвдэхээргүй байвал одоогийн Ерөнхийлөгчийн сонгуультай хамтатгаж ард түмнээс санал асуулга авах юм. Ингэж чадвал цаг хугацаа хэмнэнэ. Ирэх жил энэ ажлыг хийж чадсан байвал би хувьдаа амжилт гэж харж байна. Ер нь Үндсэн хуулийг өөрчлөх ёстой гэж 10 гаруй жил ярилаа. Учир мэдэх хүмүүс эрс өөрчлөх ёстой, өөрчлөх хэрэггүй, хуулиа хэрэгжүүл гэх мэт янз бүрийн байр суурьтай байна. Олон жилийн явцад амьдралд нийцэхгүй зүйл гарч, тодотгол хийх цаг болжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

“Та нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа гэсэн үг үү?”

-Би хувьдаа зөвлөлдөх санал асуулгын дүнд өөрчлөлт оруулах зүйтэй гэсэн дүгнэлт гарна гэж найдаж байгаа. Үндсэн хуулийн суурь зарчмыг өөрчлөхгүйгээр давын өмнө жижиг сажиг өөрчлөлтийг хийх нь зүйтэй. Суурь зарчмыг өөрчилнө гэвэл том ажил болно. Анх Үндсэн хууль баталсан шиг хэмжээний ажил өрнөх байх.

“Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан хүний хувьд бусад улс орнуудын Үндсэн хуульдаа хэр давтамжтай өөрчлөлт оруулдаг талаар судалж байв уу?”

-Миний мэдэхээр ЗХУ 15 улс болж задарсан. Монгол шиг ардчилал зах зээлийн замыг сонгосон 20-иод улс бий. Энэ шинэ тутам бий болсон улсууд Үндсэн хуульдаа шуурхай өөрчлөлт оруулаад явж байгаа. Уламжлал, хэзээнээс хуулиа мөрдөж эхэлсэн гээд олон зүйл нөлөөлдөг байх. Монгол Улс бол 1924 оноос Үндсэн хуультай болсон. Олон оронд суурь хуулиа юм л бол хөндөөд байхыг сайн зүйл гэж үздэггүй. Тийм үзэл баримтлал ноёрхож байдаг. АНУ л гэхэд 200 жилийн түүхтэй Үндсэн хуульдаа хоёр, гуравхан удаа л нэмэлт, өөрчлөлт оруулсан юм билээ. Манай улсын Үндсэн хууль нэлээд дэлгэрэнгүй хуулийн тоонд орно. Дэлгэрэнгүй учраас амьдралд нийцүүлж өөрчлөх шаардлага тулгараад байна. [ЗГМ]

ЭШЛЭЛ

Хятад хэдийгээр социалист орон боловч шашин, соёлоо сайхан авч явдаг. Манай улс ч гэсэн шашин, соёлын талаараа Үндсэн хуульд тодорхой зааж өгөх хэрэгтэй гэж би боддог. Шашин хүний сэтгэлийг эрхшээж, төр хүний биенийг эрхшээдэг гэдэг. Номонд байхгүй хэрнээ буурлуудын тархинд байгаа мэдээллийг бид буулгаж авах хэрэгтэй. Энэ бол үндэсний аюулгүй байдлын нэг үндэс гэж үзнэ. Хөгжлийн гарц юу вэ гэвэл доллар, төгрөгөөс гадна хүмүүсийн ёс суртахуун юм. Монголын эдийн засаг, нийгмийн хямрал угтаа ёс суртахууны доройтлоос үүдэлтэй гэдэгт би эргэлздэггүй. Их эзэн хааныхаа “Мах идэх шүд хүнд, хүн идэх шүд сэтгэлд” гэж хэлснийг санаж явууштай.

УИХ-ын гишүүн
Р.Раш



НАМУУД “Гурван тэрбумын тухай яриагүй”

Парламентад суудалтай намууд ирэх сарын 2-6-нд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдээ тодруулах тов гараад байгаа. Намуудын нэр дэвших магадлалтай хүмүүсийн мэдээлэл олон нийтэд тархаад байна. Сонгуулийн сургаар намуудын хандивын асуудал ч сөхөгдөх боллоо. МАН гэхэд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээсээ гурван тэрбум төгрөгийн хандив авна гэх мэдээлэл чих дэлссэн. Энэ талаар УИХ дахь МАН-ын

бүлгийн дарга Д.Хаянхярваа “Гурван тэрбум гэж сонсоогүй тоо байна. МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж, сонгуулийн хандив цуглуулах Ажлын хэсэг хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг хандивын асуудлаар хуралдаагүй. Бид хандив цуглуулахдаа хуулийн хүрээнд ажиллана. Сонгуулийн хуулийн хүрээнд аж ахуйн нэгж, хувь хүн, иргэд рүүгээ хандаж, хандив цуглуулах ажлыг зохион байгуулна” гэсэн тайлбар өглөө. Тэрбээр тус Ажлын хэсгийн ахлагчаар ажиллахаар болжээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017.04.25

Тендер шалгаруулалтын нэр: **АГААРЫН ХӨЛГИЙН МОДЕЛЬ НИЙЛҮҮЛЭХ компанийг сонгон шалгаруулах тендер**
Тендер шалгаруулалтын дугаар: **15/2017-М**

МИАТ ХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **АГААРЫН ХӨЛГИЙН МОДЕЛЬ НИЙЛҮҮЛЭХ** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөгийг МИАТ ХК-ийн төв байрны кассанд тушааж доорхи хаягаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Санхүүгийн чадавхийг харуулах 2014, 2015, 2016 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан; аудитийн дүгнэлтийн хамт. Сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл, нотлох баримтын хамт ирүүлнэ. Ирүүлж буй үнийн саналын 2 хувьтай тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ. Сүүлийн 3 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь: 115 сая төгрөгөөс багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 115 сая төгрөгөөс багагүй байна. Тендерийг 2017 оны 05-р сарын 26-ний өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 05-р сарын 26-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ. Гадаадын хуулийн этгээд тендерт оролцох боломжтой. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХАЯГ: Хан-Уул дүүрэг, 10-р хороо
МИАТ ХК
Харилцах утас: 7004-9860, 9904-5326
Факс: 976-11-7004-9919
Өрөөний дугаар : Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот

ТОВЧХОН

» **ЕРӨНХИЙЛӨГЧ**

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ сарын 24-25-нд Дорнод аймагт ажиллаж байна. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009-2017 оны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг Дорнод аймгийн иргэдэд танилцуулах аж. Энэ үеэр Дорнод аймгийг Төрийн дээд Сүхбаатарын одонгоор шагнах ёслол болно.

» **МАХН**

Ирэх сараас эхлэн намууд Ерөнхийлөгчид нэр дэвшигчээ тодруулж нэрсийг нь зарлахаар ээхэж байна. МАХН л гэхэд Гадаад хэргийн сайд асан Л.Эрдэнэчулууныг нэр дэвшүүлэхээр ярилцаж байгаа аж. Л.Эрдэнэчулуун нь 2000 онд их өрийг тэглэх явцад гар бие оролцсон, хоёрдугаарт төрд ажилласан дадлага туршлагатай, сүүлийн 10 гаруй жил төрийн ажилд оролцоогүй нэр цэвэр улстөрч хэмээн үзсэн байна.

» **ТОО**

99.8 тэрбум
Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2017 оны нэгдүгээр улиралд 99.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеэс 78.3 (4.6 дахин) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 32.7 (3.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна.

» **УУЛЗАЛТ**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд даваа гарагт Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Суреш Бабуг хүлээн авч уулзлаа. Энэ үеэр талууд Энэтхэгийн Засгийн газрын тэтгэлгээр сургах монгол оюутны тоог нэмэгдүүлэхээр ярилцав.

» **ХҮСЭЛТ**

О.Баасанхүүгийн байрлаж байсан өрөөнд Ардчилсан намын дарга, УИХ-ын гишүүн С.Эрдэнийг оруулахаар зохицуулалт хийж, түүнийг өрөөгөө суллахыг шаардсан байна. Тэрбээр үүнд бухимдаж, Улаанбаатар хотын Засаг дарга С.Батболд болон Сүхбаатар дүүргийн Засаг даргаас Сүхбаатарын талбайд гэр барих зөвшөөрөл хүссэн байна. Тэрбээр ард түмэнтэйгээ ойр байхын тулд Сүхбаатарын талбайд гэр барьж суух шийдвэр гаргалаа хэмээн сэтгүүлдэд тайлбарлав.

» **ХАМТЫН АЖИЛЛАГАА**

2017 оны улсын төсөв болон төсвийн тодотголын төсөлд санал өгсөн ч дэмжлэг аваагүй эмнэлэг, сургууль, цэцэрлэг, соёлын төвийн барилгыг шинээр барих, их засвар үйлчилгээ хийх, дэд бүтцийг шинэчлэх зарим ажлыг Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг /ТИКА/ санхүүжүүлэхээр боллоо.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **OPED@ZASAG.CO**

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Тансаглалаа зогсоож, ажилчдын цалинг нэмэхийг шаардав

Ажилчдын цалинг 10 хувь нэмэхийг шаардсан маргаан тухайн үед ТУЗ-ийг гацааж байжээ

Г.Байгал
@baigalZGM

“Эрдэнэт” хяналтгүй болж байна. Төрөөр бамбай хийсэн амьгүй албатууд түмний өмчийг хайр найргүй цацаж, хяналтгүй цөлмөж эхэллээ. Зоосны төлөө “Эрдэнэт”-ийг зольж буй тэдэнд үйлдвэрийн ирээдүй, ажилчдын эрх ашиг падлийгүй мэт. Тий-мээс ажилчдын эрхийг уландаа гишгэж, хувийн хэвшлийн шаардлагад хаалттай хаалгаар хариу барив.

“Монголын зэс” корпора-цийн гүйцэтгэх захирал Ц.Пүрэвтүвшин “Эрдэнэт”-ийн ирээдүй, ажилчдын эрх ашгийг хамгаалсан гурван зүйл бүхий шаардлага хүргүүлэхээр даваа гарагт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт (ТӨБЗГ) ханджээ. Тэрбээр шинэ удирдлагын хэрээс хэтэрсэн тансаглал, дарга дагасан халаа, сэлгээг зогсоож, ажилчдын цалинг багаар бодоход 10 хувь нэмэхийг шаардсан байна.

Гэтэл ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осор өрөөгөө дотроосоо түгжих нь холгүй, өөрийгөө нуужээ. Ингээд зогсохгүй “босго бүү давуул” гэж хамгаалагчдаа захиад, хувийн хэвшлийн төлөөллийг хавьтуулаагүй байна. Бас хамт очсон хэвлэлийнхнийг ч халгаагаагүй аж. Шахаачдаас “төрсөн” увайгүй албатууд энгийн иргэн, жирийн ажилчид руу ийнхүү нуруугаа харуулж байна. Тодорхой өгүүлбэл, энэ бол “Эрдэнэт”-ийг үүрч яваа энгийн ажилчдад хандаж буй төрийн албатуудын төрх. Үл ойшоосон энэ мэт үйлдэл үүгээр дуусахгүй нь харамсалтай. Үүнээс өмнө ч үйлдвэрийн ажилчид руу нулимж байсан удаа бий.

Өнгөрсөн хоёрдугаар сард болсон “Эрдэнэт” үйлдвэрийн ТУЗ-ийн хурлаар 49 хувийг эзэмшигч “Монголын зэс” корпораци үйлдвэрийн удирд-лагуудын цалинг хэвээр үлдээж, ажилчдынхыг 20 хүртэл хувиар өсгөх санал гаргажээ. 6000 шүргэсэн ажилчдын цалинг ихдээ 20, доод тал нь 10 хувиар өсгөх боломжтой гэсэн тооцоо, судалгааг ч хийсэн байна. Гэвч яг цалин нэмэхийн даваан дээр төрийн албатууд хувийн өмчийг хууль бусаар дээрэмдэн авч, хяналтаа тогтоосон үйл явдал өрнөсөн.

Ийн балмад үйлдэл хий-гээд зогсохгүй хууль зөрчин, булаасан үйлдвэрийг хувааж идэхээр яаравчлав. Уулын бая-жуулах “Эрдэнэт” үйлдвэрийг 100 хувь төрийн өмчөөр бүртгэх шийдвэр гарснаас хойш ганц ч хонож амжаагүй шахам байхад хууль бус ТУЗ хуралдсан. Яаран хийсэн эл хурлаар хувийн хэвшлийн дэвшилдсэн ажилчдын цалинг нэмэх саналыг тас нууж, хав дарахаар шийджээ. Харин оронд нь өөрсдийнхөө халаасыг түнтийлгэхээр шийдсэн байна. Улмаар жирийн ажилчдаас 10, бараг 20 дахин өндөр цалинг өөрсдийн томилсон утсан хүүхэлдэйнүүддээ олгохоор тогтсон байгаа юм. Гэхдээ энэ хэмжээний цалинг тэд өчүүхэн мөнгө хэмээн чамлаж буйг энд сануулъя.

Төрийн албатууд “Хэмнэж байна, төрийн тансаглалыг танаж байна” хэмээн хэнэг ч үгүй наанаа хэлж буй ч цаасан дээр далдуур гаргасан шийдвэр нь тэс өөрийг өгүүлнэ. Цагаан дээр хараар бичсэн гарын үсэг нь хүртэл хэлснээс нь тэнгэр, газар шиг зөрнө.



ЗГМ©

“Би хэмнэж байгаа” хэмээн цээжээ дэлдэн, даналзаж яваа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор “Эрдэнэт”-ийн шинэ ерөнхий захирлыг 300 сая төгрөгөөр автомашин авахыг зөвшөөрч, Засгийн газраас өгсөн чиглэлийг зөрчихийг нь өөгшүүлсэн байдаг. Амьгүй, увайгүй албан хаагчдын ам, ажил, үг, үйлдэл хэрхэн зөрдгийг үүнээс харчихаж болно.

бүү хэл төрийг бүсээ тултал чангалахыг Засгийн газрын тэргүүн үүрэгдсэн. Гэвч засгийн бодлогоос зөрж, Ерөнхий сайдын үгийг үл тоож буй цадиггүй дарга нарын цайрсан үйлдлийг харсаар суух уу.


Тэд идэж, уугаад зогсохгүй “Эрдэнэт”-ийг самрахаар ээх-жээ. Дарга дагасан халаа сэлгээ “Эрдэнэт” хэмээх их хөлгийг доргиож, эзэнгүй арлыг зүглэхэд хүргээд байна. Тус үйлдвэрийн удирдлагууд цех, газрын 200 гаруй даргыг сольж, мэргэжлийн ажиллах хүчийг хоморголон халахаар түрэмгийлж байна. Ингэхдээ эдгээр албан тушаал, орон тоог квот болгон хуваан авч, өөрсдийн гар хөл болсон хэн нэгнийг томилохоор зориг шулуудчихсан явна.

Ийнхүү цех, газрын хурган дарга нарын томилгоог онцол-сонд нь учир бий. “Эрдэнэт” рүү дайрч буй хууль зөрчигчдийн бүлэг мөрөөдлийн багаа бүр-дүүлж байгаа нь энэ. Ингэснээр “Эрдэнэт” рүү шахаа хийх, түмний өмчийг толгой мэдэн удирдах боломж нь саадгүй болно. Хатуухан хэлэхэд, олон нийтийн өмчөөр мөнгө угаах мафи энд бүрэлдэж, шахааны бизнес цэцэглэнэ гэсэн үг.

Учир нь тэд олон нийтийн хяналтын өмнүүр бараан хөшиг татчихсан. Хувийн хэвшлийн хяналтаас гарсан сүүлийн үед “Эрдэнэт”-ийн шилэн дансны хөтлөлт алга болов. Шилэн дансны тухай хууль хэрэгжүүлж эхэлсэн 2015 оноос өнгөрсөн оны сүүлийн улирал хүртэл төрийн өмчит “Эрдэнэт” үйлдвэр санхүүгийн урсгалаа тайлагнаж байсангүй. Харин 2016 оны есдүгээр сараас эхлэн үйлдвэрийн шилэн данс амилсан юм. Цаг хугацааны дарааллаар авч үзвэл ОХУ-ын эзэмшлийн 49 хувийг Монголд авчирсан “Монголын зэс” корпораци үйлдвэрийн удирдлагын багт багтсан үе. Ингэж бараг хоёр жилийн хугацаанд салхи ороогүй “Эрдэнэт”-ийн шилэн дансанд гэрэл тусгасан. “www.shilen-dans.gov.mn” цахим хуудсанд байрлах “Эрдэнэт”-ийн шилэн дансанд өнгөрсөн оны есдүгээр сараас Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн мэдээллээ нийтэлж

эхэлсэн байдаг. Тодруулбал, ган бөөрөнцөг, бүхэллэг нүүрс гээд “Эрдэнэт”-ийн үйлдвэрлэлд шаардлагатай бараа, бүтээг-дэхүүнийг жагсаасан. Тэр

вэрийн удирдлагыг гартаа авсан даруйдаа “Эрдэнэт”-ийг эргээд хаалттай “вант улс” болгочихлоо.



“Монголын зэс”-ээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хүргүүлсэн шаардлага

ч бүү хэл, бичгийн цаасыг хүртэл нэг бүрчлэн багтаасан нь “Эрдэнэт”-ийн хувьд шоо шинэ үзэгдэл байсан. Мэдээж мөнгөн дүн, санхүү тооцоо нь ч ил болсон. 2016 оны есдүгээр сард л гэхэд тус үйлдвэр бараг ес орчим тэрбум төгрөгийн худалдан авалтын саналаа ил болгосон байна. Улмаар тендерт шалгарсан компаниудын нэр, гэрээний үнийн дүнг тайлагнахаа ч мартаагүй. Ингээд “Эрдэнэт”-ийн санхүү эрүүлжиж эхэлсэн. Санхүүгийн тайлан тооцоо нь тунгалаг болж, шилний цаанаас ч нэвт харагддаг болов. Харамсалтай нь, хувийн хэвшлийн урагшлуулсан “Эрдэнэт”-ийг эрүүл болгох эмчилгээ шахаачдын гайгаар зогсов. Төрийн албатууд үйлд-

Нийтлэлийн эхэнд өгүүлсэн баримтууд бол “Эрдэнэт”-ийг хэдхэн этгээд хууль бусаар мэдэлдээ авсан энэ богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд. Халаа, сэлгээг эрчимжүүлж, удирдлагын бүтцийг данхайл-гасан. Таналтыг тансаглалаар сольж, түмний мөнгийг шам-шигдуулсан. Ингээд зогсохгүй нээлттэй болж байсан мөнгөний урсгал, санхүүгийн тайланг нь хааж, ажилчдын эрх ашгийг уландаа гишгэж, өөрсдийн хонжоог тэргүүнд тавьсан. Тэд энэ богино хугацаанд ийм увайгүй үйлдлийг л амжуулж, хоноцын сэтгэлээр хандсанаас өөр урагшилсан зүйл ширхэг ч алга.

Тэгвэл “Монголын зэс” корпораци уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн удирд-

лагад багтсан хэдхэн сарын хугацаанд юу амжуулсныг эргэн сануулъя. Тэд данхайж байсан удирдлагын бүтцийг цомхон болгосон. Цаашлаад шилэн дансыг шинээр хөтөлж, “Эрдэнэт”-ийг ил тод болгосон. Шахааны бизнест цэг тавьж, шамшигдуулах явдлыг таслан зогсоосон. Энэ бол “Монголын зэс” корпорацийн “Эрдэнэт” үйлдвэрийг Монголд эх оронч сэтгэлээр авчрахдаа анхлан амалж байсан таван зорилтын нэгээхэн хэсэг.

“Монголын зэс” таван зорилт бүхий цогц төлөвлөгөө гаргаж байв

Тэд үйлдвэрийг Монголын хөгжлийн түүчээ болгож, санхүүгийн нээлттэй, шилэн бүтцийг бүрдүүлж, нийгмийн хариуцлагатай, ажилчдадаа ээлтэй, ирээдүйг харсан “Эрдэнэт”-ийг бий болгох таван зорилт бүхий цогц төлөвлөгөөг гаргасан байсан юм. Тухайн үед үүнийг нь үлгэрийн далай болно хэмээн шоолж байсан нэгэн ч бий. Гэвч эргээд харахад энэ богино хугацаанд хийсэн хувийн хэвшлийн шинэчлэлт, өөрчлөлт ямар үр дүнтэй, зоригтой, алсыг харсан алхам байсан нь тодорхой харагдана.

Ийнхүү хагас жил хүрэх-гүй хугацаанд хийсэн хувийн хэвшлийн далайцтай шинэч-лэлийг хагас сар ч хүрэхгүй хугацаанд төрийн албатууд сөнөөж, сүйрүүлэхийг бид харж байна. Сөнөөх амархан, бүтээх хэцүү гэдэг энэ.

Ийм балмад үйлдлүүд нь энэ Засгийн газрыг ичгүүртэй, увайгүй болгон харагдуулж байна. Угтаа Ж.Эрдэнэбатын толгойлж буй засаг эдийн засгийн хямралтай зоригтой тэмцэж, Монголын төрд хэм-нэлт, гамналтын бодлогыг хамгийн хүчтэй хэрэгжүүлж буй. Гэвч хэдхэн арчаагүй албат энэ засгийг харлуулж, монгол төрийн нэрийг булингартуулсаар. [ЗГМ]

Үзэл бодол

**Бид бүх шатандаа
төлөвлөгөөгүй,
хариуцлагагүй
нийгэмд буужигнал-
даж байна**



Б.Ганбаяр / ЗГМ©

Удахгүй эхнэр маань нярайлж, бид гурван хүүхдийн аав, ээж болно. Хадмын хаяа түшиж байгаа учраас мөнгөө цуглуулаад эхний ээлжинд өөрийн гэсэн орон гэртэй болмоор байна. Хар гэртээ хаан, бор гэртээ богд гэдэг шиг. Гурван хүүхэд одоо үед олондоо орох учир машин тээргтэй болчих юм бол манай гэр бүл бошигтоод л явчихна” хэмээн ярих зуур түүний нүдэнд гэрэл тодорч байлаа. Харин гудамжинд таарсан үл таних эмэгтэй бол 30 гаруй настай. Ид хийж бүтээх насандаа яваан нэгэн. Харамсалтай нь тэрбээр хоёр хүүхдийн ээж хэдий ч насны ханиасаа салаад чамгүй олон жилийг өнгөрөөжээ. “Эхлээд байртай болмоор байна. Тэр нь зээл төлдөггүй байвал сайхан л юм. Гэхдээ ч одоо тийм мөрөрсөн юм гэж хаана байхав. Мэдээж бусдын адил машин авахыг хүсэж байна. Ер нь хэн хүнээс дутахыг хүсэх билээ. Сайн хань ижилтэй болмоор л байна шүү дээ” гэв. Энэ бол дийлэнх монголчуудын хүсэл мөрөөдөл, амьдралын нийтлэг дүр төрх гэхэд болно. Эцэг эхээс өвлөж авсан эл баялаггүй л бол насан туршдаа байр, машин авахын төлөө хөдөлмөрлөж амьдрахаас өөр аргагүй.

ДӨРВӨН ИХ НАЯДЫН ЗЭЭЛ

Орон сууцны найман хувийн зээлийг 2012 оноос олгож эхэлснээс таван жил өнгөрчээ. Үүнээсөө өмнө сард ердөө 200 орчим хүн л ямар нэг байдлаар орон сууцны худалдан авдаг байсан бол зээл олгож эхэлснээр энэ тоо огцом өссөнийг Монголбанкнаас сар бүр танилцуулдаг ипотекийн зээлийн тайланд дурдсан байна. Тайлангааг харахад 2010 онд улсын хэмжээнд ердөө 16,700 зээлдэгч байсан бол 2017 оны хоёрдугаар сарын байдлаар 89,8 мянга болжээ. Энэ нь дөрвөн ихэнхэд төгрөгийн зээл юм байна. Нэг талаар төдий олон мянган өрх хүчэл мөрөөдлөө биелүүлж чадсан нь гэрэл гэгээ мэт боловч нөгөөтэйгүүр зөвхөн зээлээ төлөхийн төлөө өглөөнөөс орой хүртэл борви бохис хийхгүй ажиллаш шаардлага тулгарч байна. Ямар сайндаа л “Төрсөн хүүгээ биш, банкны зээлийн хүүгээ бодсоор насыг барьж байна. Зээлээр авсан байрандаа унтах гэж л ордог боллоо” гэх мэтийн шог яриа цахим ертөнцөд тархаж байх вэ. Үүнийг дэнэслэн олон мянган хүн сэтгэгдлээ хуваалцаж буй нь энэ.

ГАНЦХАН ЛЗАМ БИЙ...

Ерөөс монголчуудын монгол мөрөөдөл орон сууц, автомашин хоёр дээр л тогтож байна гэхэд хилсдэхгүй л болов уу.

» 2010 онд улсын хэмжээнд
ердөө 16,700 зээлдэгч байжээ.

» Хэнээс ч дутахгүй тансаг
сайхан амьдрах боломж байна.

» Ид ажиллаж, хийж бүтээх насандаа яваа залуус гаднын улс рүү “дүрвэж” байна

Уг нь бид агуу түүхтэй, дайн дажингүй арвин баялаг улс оронд ердөө гуравхан саяааас амьдарч буй хувьтай хүмүүс. Хэнээс ч дутахгүй тансаг сайхан амьдрах боломж, боллоочу бүрэн дүүрэн бий. Гэтэл төр, засгийн зарим буруу бодлогын хар балгаар хоногийн хоолоо яах вэ гэсэн асуултад унаж, байрных лизингээ төлж чадахгүйд хүрч, арайхийж авсан байрнаасаа хэзээ мөдгүй хөөгдөх эрсдэлтэй сараа бүр тулгарч, хэцүүхэн л амьдрах байна. Монгол хүн амны билгээс ашдын билэг гэдэг ч үнэндээ амьдрал ийм л байна. Тийм учир болохоор монгол залуус эх орноосоо дүрвэж, харийн нутагт хэдэн халтар төгрөгийн төлөө хайртай аав ээж, халамжит ханы ижил, үр хүүхэд, гэр бүл, амь наан, эрүүл мэндээ золин байж мөрөөдлийнхөө төлөө явсаар Өнгөрсөн онд 4000 гаруй залуучад харийн нутагт хар ажил хийхээр явсан бол, энэ жил 8000 хүнийг бүртгэнэ гэсэн бараан тоол

харагдлаа.

Дэлхийн нөгөө талд сирин хүүхдүүд хэдэн зуугаараа бөмбөгдүүлж, амь үрэгдэж байна. Харин Монголд энх тайван, амар амгалан ноёрхсоор атал идэвхжиллэж, хийж бүтээх насандаа яваа залуус гаднын улс руу “дүрвэж” байгаа нь эмгэгнэлтээ Тэдэнд үнэндээ үүнээс өөр гарш үлдээгүй шүү эгээ. Улс орны эдийн засаг элгээрээ мөлхөж, компаниуд шил шилээ даган, дампуурсаар байхад өөр яах билээ. Долоон төрлийн татвар нэмэх “нүдээ олсон” шийдвэр нь тэднийг улам цааш түлхэж байна. Монголчуудын хамгийн өргөн хэрэглэдэг “Prius” машины татварыг нэмэх шийдвэр нь амьдралаа дээшлүүлье гэсэн олон залуусын хүслийг мохоож орхилоо. Удахгүй түлшний үнэ ч тэнгэрт тулахаар болчихлоо. Үүнийг нь дагаад нэг өглөө сэрэхэд 1200 төгрөг гэж байсан талх 1500 төгрөг болно биз. Ингэж бараа бүтээгдэхүүний үнэ өдрөөс өдөрт “сэмхэн” нэмэгдэх ч гар дээр буух цалингийн хэмжээ нь бахь байдагаараа л. Шударга бус биш гэж үү. Баралт хүүхдийнхээ нэрийг мартахаа шахан өглөөнөөс орой хүртэл бүтэн нэг сар ажиллаж авсан цалин нь байрны зээл, автобус унааны мөнгө, хоол хүнсэнд хэрэхтэй үгүйтэй л байна. Монголчууд урд хормойгоо хойд хормойгоороо нөхөж өдөр хоногийг өнгөрөөсөөр. Ингэж амьдрахыг хүсэхгүй, энэ байдлаас залхан залуусын цорын ганц сонголт нь гаднын оронд нөхөй мэт ажилла. Өдөрт 100-

300 мянган төгрөгийн цалин авахын тулд манай залуус өнөөдөр эх орноосоо дүрвэж байна.

**БОДЛОГОГҮЙ
УЛСЫН БАЛАГ**

Бид хүмүүнлэг иргэний
ардчилсан нийгэм байгуулж,
капитализмын замаар замнаж
буй мэт боловч үнэндээ дээрх
хоёр замналаасаа байнга ха-

зайж байна. Одоо “мөрдөж” буй Монгол Улсын хөгжлийн бодлого бол сонгуулийн дөрвөн жилд зориулсан амалтын жагсаалт төдий. Улс орон байтугай хувь хүн, гэр бүл, компаниуд ч урт хугацааны төлөвлөгөө гаргаж, хөгжлөө тодорхойлдог нь үсрэнгүй орнуудын амжилтын хэв маяг. Бид бүх шатандаа төлөвлөгөөгүй, хариуцлагагүй нийгэмд бужигналдаж байна.

Засгийн газар нь ямар ч шийд-
вэрээ дуртай цагтаа өөрчлөх
магаддалтай, төгрөгийн ханш-
лахрхэн хэлбэлзэхийг нэг
жилийн өмнө байтугай сарын
өмнө ч мэдэх боломжгүй. Улс
орон маань хаашаа явж байна
вэ. Ерөөс бидэнд үндэсний
хэмжээний мөрөөдөл байна
уу. Энэ мэт олон асуултын
хариултыг иргэд нэхэж байна,
төр заагаас. [ЗГҮ]



Долоон төрлийн
татвар нэмэх
“нүдээ олсон”
шийдвэр нь
тэднийг улам л
цааш нь түлхэнэ.
Монголчуудын
хамгийн өргөн
хэрэглэдэг
приус машины
татварыг нэмэх
шийдвэр нь
амьдралаа
дээшлүүлй
гэсэн олон
залуусын
хүслийг мохоож
орхилоо.



TransBank
ТӨВӨН ХӨГЖЛИЙН БАНК

БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ ДАХИН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Тээвэр Хөгжлийн Банкны хувьцаа эзэмшигчид Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалт зарлаж байна. Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлж, нийт оролцогч талуудын итгэлцлийг бэхжүүлэх үүргийнхээ хүрээнд Тээвэр Хөгжлийн Банк ийнхүү ТУЗ-ийн бүрэлдэхүүнээ шинэчилж байгаа болно. Монгол улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйл, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын хамтарсан А-42/34/49 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулан баталсан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвцүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ыг үндэслэн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулна.

Дор дурдсан шаардлагад нийцсэн хувь хүмүүс бичгээр гаргасан хүсэлтээ бүрдүүлэх бичиг баримтын хамт 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 18:00 цагаас өмнө Тээвэр Хөгжлийн Банкны Хүний нөөцийн хэлтэст хаяглан Жуулчны гудамж-35, Улаанбаатар-15170-т байрлах Тээвэр Хөгжлийн Банкны Төв оффист ирүүлнэ үү.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Тээвэр Хөгжлийн Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Банкны тухай хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ТУЗ-ийн гишүүдэд тавигдах үндсэн шаардлагаас давна Банкны тухай хуулийн 33.3 дугаар зүйл, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын хавсралт 1-т заасан дараах шаардлагуудыг хангасан байна.
- Холбогдох хууль, тогтоомжид заасан ТУЗ-ийн гишүүдэд тавигдах бүх шаардлага;
- Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ наймаас доошгүй жил ажилласан, үүнээс дөрвөөс доошгүй жил банк, санхүүгийн байгууллагод эрх бүхий албан тушаал хашсан байх;
- Төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх;
- Эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүйг нотолсон байх;
- Банкны эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээд бүх байх;
- Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч бус байх, эсхүл уг этгээдтэй холбогдох этгээдийн хамааралгүй байх;
- Сүүлийн таван жилийн хугацаанд Тээвэр Хөгжлийн Банканд ажиллаагүй байх;
- Банкны үйл ажиллагааны үр дүнгээс хамаарч урамшуулал авдаггүй байх;
- Тухайн банканд ТУЗ-ийн гишүүнээр наймаас дээш жилээр ажиллаагүй байх;
- Банкны тухай хуулийн 3.11.2-т заасан банкны хувь нийлүүлэгч, томоохон харилцагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан бус байх.

БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ:

- Монгол хэл дээр өөрийн товч намтар;
- Цахим иргэний үнэмлэхний нотариатаар батлуулсан хуулбар;
- Дээд боловсролын дипломын хуулбар.

Танин мэдэхүй



The New York Times©

Оросын нууц

Орос эмэгтэйчүүд технологийн талбарт цойлж буйн учир

З.Гэрэл
ЗГМ

Москвагаас холгүй орших Зеленоград хотод аж төрдөг Ирина Корошко таван настайгаасаа үржүүлэхийн хүснэгтийг цээжилж эхэлжээ. Ирина математикт эрт дурласан. Энэ ухааныг гаргууд эзэмшсэн гэр бүл, хичээл бүрээ нэг том асуудлыг шийдвэрлэх тоглоом болгочихдог авьяаслаг багшийнхаа ачаар тэрбээр Г.В.Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуульд эрсдэлгүй элсчээ. “Тоо, тооцоололд ямар их хүч байдгийг би лекц бүрээсээ ухаардаг байлаа. Надад ямар ч зүйлийг урьдчилан тооцоолох чадвар өгдөг ид шидтэй хичээл байсан” хэмээв.

Одоо 26 настай Ирина Оросын зээлийн цахим үйлчилгээний “ID Finance” компанид өгөгдлийн мэргэжилтнээр ажилладаг. Зээлийн эргэн төлөлт хэр зэрэг найдвартай байхыг тооцоолдог загвар боловсруулах ажилдаа тэр их сонирхолтой. Иринагийн түүх Орост онцгой тооцогдохгүй.

Харин бусад улс оронд бол онцгой байж мэдэх юм. Учир нь охид шинжлэх ухаан, технологи,

инженер, математикт дурлах сонирхол нь хэдий чинээ эрт эхлэх тусам эргээд төдий хэмжээгээр сонирхолгүй болдог аж. Тэгээд эргэж сэргэдэггүй байна. Үүнийг нотлох судалгаа ч нэлээд бий. Технологи, инженерийн салбарын карьерийн өндөрлөгт ч эмэгтэйчүүд харьцангуй цөөн байдаг нь үүнтэй холбоотой. Яагаад гэх асуултад саяхан “Microsoft”-ийн явуулсан судалгаа ийн хариулж байна.

Тус компани Европын 11500 залуу бүсгүй, охидтой энэ талаар ярилцлага хийжээ. Дийлэнх нь технологи, инженер, шинжлэх ухаан, математикийг сонирхох сонирхол 15 настайгаас нь огцом буурдаг гэдгийг хэлсэн байна. Үүнд хүйсийн онцлог, энэ салбарт даган дуурайх эмэгтэй мэргэжилтэн дутмаг, эсрэг хүйсийнхний шахалт болон гэр бүл, багшийн зүгээс дэмжлэг дутмаг гээд олон хүчин зүйл нөлөөлдөг байна. Цаашлаад энэ чиглэлийн мэргэжлийг сонгоход нь багш, гэр бүлийн зүгээс буруутгах хандлага их байдаг аж.

Харин Орост байдал өөр. ЮНЕСКО-ийн судалгаагаар дэлхий дахинд шинжлэх ухааны судалгааны салбарт ажиллагсдын 29 хувь нь эмэгтэйчүүд. Гэтэл Орост 41 хувьтай. Мөн Их Британийн зохион бүтээгчдийн дөрөв, Оросын 15 хувь нь эмэгтэйчүүд.

Үүний шалтгаан нь Орост охид дээрх салбарыг судалж, ажиллах боломж маш өргөн байдагтай холбоотой. Ийм

боломжтой орчин бол охид эрт эхэлсэн сонирхлоо даган салбартаа тууштай суралцаж, ажиллах нөхцөл гэдгийг “Microsoft”-ийн ярилцлагын судалгаанд хөндлөнгийн дүгнэлт хийсэн KRC судалгааны үйл ажиллагаа хариуцсан захирал Жулиан Ламбертин тайлбарлав. Тэрбээр “Бусад охид тэдгээр хичээлийг арай хөнгөн, саваагүй байдлаар сонгодог бол орос охид ирээдүйд энэ салбарт ажил эрхлэх боломж өндөр учраас сонголтдоо нухацтай ханддаг” гэв.

Шинжлэх ухааны салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн тоогоор Орос тэргүүлдэг

Ярилцлагад оролцсон эмэгтэйчүүд эцэг, эхийн дэмжлэг болон салбарт үлгэр жишээ болсон хэн нэгний нөлөө маш чухал гэдгийг тэмдэглэсэн байна. Үүнээс гадна эмэгтэй багш нар харьцангуй олон тул хичээлийн үнэлгээндээ ч хүйсийн ялгаварлалгүй хандах нь чухал хүчин зүйл болдог аж.

Их Британийн өсвөр насныхны математик болон физикийн хичээлэйн талаарх бодлыг нь дүгнэхэд “эрэгтэй, тэгшитгэл, уйтгартай, нэгэн хэвийн, хэрэгцээгүй” гэсэн таван үг л хангалттай байв. Гэтэл Орост

эдгээр салбарыг ийм гутранги байдлаар дүгнэдэггүй гэдгийг ноён Ламбертин хэлэв. Тэрбээр “Оросуудыг гүйцэх үнэхээр хол байна. Тэнд хүйсээс илүү сайн гүйцэтгэл үнэлэгддэг” гэж тайлбарлалаа.

Оросын авьяаслаг боловсон хүчнүүдийг Их Британид өндөр цалинтай, ирээдүйтэй ажлаар хангахад зуучилдаг “Tech London Advocates” фирмийн Оросын хэлтсийг хариуцсан Алина Безуглова ОХУ-ын шинжлэх ухаанд эмэгтэйчүүдийн байр суурь ийм баттай байдаг нь шинжлэх ухааны дэвшлийг үндэсний тэргүүлэх бодлогод авч үзсэн ЗХУ-ын гавьяа гэдгийг онцолсон байна.

Москвагийн Физик, технологийн хүрээлэнгийн туслах профессор Эмили Драл ч түүнтэй санал нэг. Эмили шинжлэх ухааны салбарт хөл тавьсан түүхээ дурсахдаа “Дунд сургуулийн математикийн гүнзгийрүүлсэн сургалттай ангид хоёрхон охин байсны нэг нь би. Тэр үед надад амжилттай ажиллах боломжтой гэдэг итгэл төрсөн. Бид хөвгүүдээс илүү гэдгээ баталж, амжилт олохын тулд өөрсдийгөө улам дайчилдаг байсан” гэв. Мөн энэ салбарт хэдий цөөнх ч орос эмэгтэйчүүд өөрсдөөдө итгэлтэй байдгийн нэг нууц нь эцэг, эх нь багаас нь хангалттай дэмжлэг үзүүлдэг. Эмили ч “Би өөрийгөө яагаад математик, инженерийн ухаанд дуртай юм бол гэж хэзээ ч асууж байгаагүй. Угаасаа л ийм гэж боддог” гэв. [ЗГМ]

ФИЗИК

“Сөрөг масс”-тай матери гаргаж авчээ

АНУ-ын физикчид үйлчилж буй хүчнийхээ эсрэг чиглэлд хөдөлдөг сөрөг масс бүхий шингэнийг гарган авч, судалгааны маш том объект болгон ажиглаж байна.

Дэлхий дээр аливаа биетийг түлхэхэд түлхсэн чигийн дагуу хөдөлдөг. Энэ харилцан үйлчлэлийг Исаак Ньютоны хөдөлгөөний хоёрдугаар хуулиар тайлбарладаг.

Цахилгаан цэнэг эерэг, сөрөг туйлтай байдгийн адил аливаа матери сөрөг масстай байх нь онолын хувьд боломжтой юм. Вашингтон мужийн их сургуулийн профессор Питер Энгельс болон түүний багийнхан рубидийн атомыг үнэмлэхүй тэг градус (ойролцоогоор цельсийн -2730C) хүртэл хөргөж, Бозе-Эйнштейн конденсат гэх шингэнийг гаргаж авсан байна. Ийм төлөвт орсон шингэн

туйлын удаан хөдлөх бөгөөд яг л давалгаа шиг болдог. Атомууд нэгэн зэрэг хөдлөх бөгөөд ингэхдээ энергийг алддаггүй. Тиймээс супер шингэн хэмээн нэрлэжээ.

Бозе-Эйнштейн конденсатыг гаргаж авахын тулд судлаачид лазер ашиглан урсах чиглэлийг нь өөрчилсөн байна. Атом лазерын хязгаараас гармагц сөрөг масстай болжээ. Уг туршилтыг хийсэн судалгааны багийн профессор Майкл Форбес “Та сөрөг масстай материйг түлхэхэд эсрэг чиглэлд хөдлөх болно. Рубидийн атомын хувьд яг л үл үзэгдэх ханыг мөргөж байгаа мэт харагдана” хэмээв.

Энэхүү үзэгдлийг үргэлжлүүлэн судлах нь харанхуйн энерги, хар нүх, нейтрон одод зэрэг сансар огторгуйн үзэгдлүүд болон сөрөг массын хоорондын харилцааны учрыг олох өргөн боломж нээж өгөх юм. [ЗГМ]

ГАЗАР ЗҮЙ

Газар хөдлөлтийн давуу тал

Байгалийн гамшгаас давуу тал олж авна гэдэг хэзээ ч бүтэхгүй мэт. Харин өнгөрсөн жил Шинэ Зеландад болсон газар хөдлөлтийн дараагаар орон нутгийнхан далайн эргийн хамгаалалтад зарцуулах байсан хэдэн сая ам.доллараар хэмнэжээ.

2016 оны арванхоёрдугаар сард Шинэ Зеландын Өмнөд арлын Каикоура хотод болсон 7.8 магнитутын хүчтэй газар хөдлөлтийн үеэр хоёр хүн амиа алдсан билээ. Гамшгийн үед Каикоура хотын эргийн уртаас 120 км нь 1-8 метрээр өргөгдсөн

хөдөө аж ахуй

Цөлд ургуулсан улаан лооль

Нар хийгээд далайн дундрашгүй их нөөцөөр австраличууд цөлд нарийн ногоо тариалж, экспортолж байна.

Уг нь уламжлалт аргаар энэ бүгдийг цөлд ургуулна гэдэг бүтэхгүй. Ядаж л цэвэр ус, эрчим хүчний дэд бүтэц байх хэрэгтэй. Гэвч нөөц нь улам бүр хумигдаж буй. Энэ бүгдээс татгалзах арга замаа Өмнөд Австралийн элсэн цөлд байрладаг “Sundrop” ферм олж, хэрэгжүүлж байна. Жирийнээс хэд дахин илүү амттай, амин дэмээр баялаг улаан лоолрийг цөлд ургуулахад гүний ус, оолборлох түлш, цахилгаан болон хөрс, цаашлаад тариалангийн талбай ч хэрэггүй. Зөвхөн нар,

далайн ус байхад л хангалттай аж.

“Sundrop” фермд 23 мянган дэлгэц бий. Эдгээрийн тусламжтай нарны эрчим хүчийг хуримтлуулан, хүлэмжээ халаах, сэрүүцүүлэх цахилгааны эх үүсвэрийг гаргаж авахаас гадна далайн усаа ч давснаас нь салгаад авчихдаг байна.

Харин жимс ногоогоо хөрсөнд биш, усанд тарьдаг. Нэг га-гаас авч буй ургачийн хэмжээ уламжлалт газар тариалантай адилхан. Хөдөө аж ахуйн фермүүдийн хаягдлыг багасгаж, эрчим хүчийг хэмнэх санаачилгыг амжилттай хэрэгжүүлж буй тус ферм улаан лоолийн ургацаа 15 мянган тонн болгохоор ажиллаж буй. [ЗГМ]



UBshop.mn

ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМ

Юу авмаар байна? Юу зармаар байна?

АВТОМАШИН

1 SONATA-6 маш хямд зарна 2-3 хоногийн өмнө орж ирсэн.
Утас:96481125
2Ааны зориулалттай автомашин маш хямд зарна.
Утас: 997961159, 99087992
3ersedes Benz E-200 дизель авто машин зарна. 2004 оны 2011 онд орж ирсэн дизель 2000cc автомат. Хот дотор 10 иднэ. Германаас орж ирсэн. Тогтмол дулаан гражжид байдаг. Хар өнгөтэй E 200.
Утас: 99289768
225/60/R16 Kumho Solus дугуй
4рна.
Утас: 99135791
Nissan Teana зарна.
5Утас: 99796159
2001 оны 2012 орж ирсэн. ямар ч
6удалгүй Prius 11 зарна.
Утас: 99892976
Ачааны зориулалттай автомашин
7аш хямд зарна
Утас: 96481125, 99087992
8Автомашины хагарч пуурсан шил наагч зарна.
Утас: 99679962

КОМПЬЮТЕР БА ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

1 Skynet-ийн modem зарна.
Утас: 80286525, 86203222
23 дугаар үеийн i5 процессор, 2 GB ram, 583 GB хард диск, 15.6" дэлгэц бүхий Toshiba Satellite C850 модель нөүтбүүкнийг утасгүй маус, цүнхний хамт зарна.
Утас: 95530099
3Оргинал Wifi хүлээн авагч хямд зарна.150 метр хүлээн авна.
Утас: 91228822, 95228822
4Notebook үнэ тохирч худалдаж авна. Ломбарднаас чөлөөлж авна.
Утас: 91228822 95228822
5900x400x2mm pad хямд зарна.
Утас: 91228822, 95228822
6Пролонон хамгаалалттай, 5.5 см диаметртэй. Хүмүүсийн сонирхлыг татахуйц дизайнтай, гар утас, компьютер, нөүтбүүк, бусад төхөөрөмжинд залгаж болно. LED гэрэлтэй, дотроо батарейтай. 3.5mm аудио, USB цэнэглэгч кабель дагалдана. Өнгөний сонголттой.
Утас: 96012938, 88512938

ҮЛ ХӨДЛӨХ

140 тонн контейнер маш хямд зарна.
Утас: 90666913 96481125
2Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна.
Утас: 99289768
3Ар хустайн зусланд цэвэр агаарт хаус зарна.
Утас: 99289768
42 өрөө үйлчилгээ явуулах боломжтой байр зарна БЗД 8-р хороо Баянзүрх хотхон 108-р байрны 1-р давхарт дэлгүүр, сургалт, цэцэрлэг, үйлчилгээ явуулах боломжтой 43 мкв 2 өрөө байр хямд зарна. Хаяг: Офицерийн тойргоос уруудаад Баянзүрх хотхон 108-р байр
Утас: 80612065
5Апартмент-88 орон сууц ХЯМД зарна УТАС: 99289768
Сансарын тунелд 1 давхарын 3 өрөө байр зарна.
Утас: 99760217, 99101271
6Хотын төвд бүрэн тавилгатай пентхаус гал тогоо тусдаа 5 өрөө байр хөлслүүлнэ.
Утас: 99760217, 99101271
7Сансар Цагдаа хотхоны зүүн талд 2016он ашиглалтанд орсон 2 өрөө 41,1 мк2 байр хямд зарна.
Утас: 91228822, 95228822
8Засвар хийсэн 1 өрөө байр түрээслүүлнэ.наран талдаа цонх-той.
Утас: 99188626, 86269918
9Төв аймагт 6 айлын зуслан-гийн газар зарна.
Утас: 95347403

НОМ, ХЭВЛЭЛ

1"МАНАН БУДАН" Цоо шинэ зарна.
Утас: 85828384
2Бүх төрлийн ном хэвлэл худалдаалж байна.
Утас: 99144154
3Хуучин номнууд зарна.
Утас: 94640105
4Бизнес удирдлагын магистерийн ангид хэрэглэгдэх 2003-2008 оны Pearsons international edition номнуудыг тус бүр 30,000 төгрөгөөр зарна.
Утас 99153637
5Ээж ба хүүхэд ном зарна.
Утас: 99089401
6Түүхийн хэдэн зуун үйл явдлыг Чингисийн үеийн их бага тулалдаанаас авахуулаад Хадгаламж зээлийн хоршооны хэрэг хүртэл бүртгэн багтаасан. Чингисийн үеийн хэдэн алдартныг эс тооцвол То ван, Мянгат гэсэн хоёрхон монгол хүн багтсан байдаг бол энэхүү Britannica 8 боть ширээний нэвтрэхий толь зарна.
Утас: 88170048

ХУДАЛДАНА

Хөшигийн хөндийд шинэ нисэх явах зам дагуу гурван айлын тэгшхэн эзэмшлийн газар хямд зарна.
Утас: 98116088, 98116067

ЦАХИЛГААН БАРАА

1Электрон жин худалдана. Алт, мөнгөн эдлэл болон эмийн тунг жигнэх зориулалтай. Авсаархан хөнгөхөн. LCD дэлгэцтэй. 200 гр хүртэл Хэмжээ: 115X65X15 мм, Жин: 95 гр 1 минутанд автоматаар унтарна. Тэжээл: 2 AAA батарей (дагалдахгүй) Ажиллах температур: 10-30 хэм (C)
Утас: 88512938, 96012938
2USB гагнуурын алх. Агшин зуур хална, хөрнө. 480 C градус хүртэл хална.
Утас: 96012938

ГАР УТАС

1Америкийн BLU брэндийн STUDIO X8 HD гар утас -2 СИМ-тэй.
Утас: 96012938, 8851293
250-60 мянгад Android утас худалдаж авна. Note1 f100 f200 гэх мэт.
Утас: 91228822 95228822
3iPhone 7 plus black 128GB цоо шинэ хайрцагнаас нь задлаагүй. 128GB. 2 сая 400-аас яриад өгнө.
Утас: 93117711, 89808313

ХОТЫН ТӨВД НОМИН ИХ ДЭЛГҮҮРИЙН АРД БАЙРШИЛТАЙ ҮЙНЭЭР АШИГЛАЛТАНД ОРОХ БИЗНЕС ТӨВД ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙ ДАВХАААР НЬ БОЛОН ЦӨӨН ТООНЫ ОФФИС ХУДАЛДАНА.

96028751, 99093501

UBSHOP.MN

ubshop.mn сайтад та зараа байрлуулбал манай сонины зарын энэ хэсэгт шууд орох юм. Зөвхөн кирил үсгээр бичсэн, холбоо барих утас, зарах үнэ нь тодорхой зарууд энэ хэсэгт орохыг анхаарна уу.



Улаанбаатар

Чимээгүй шимэгчлэх хөрсний бохирдол

Нийслэлийн худалдаа үйлчилгээний газрын орчимд шиветрийн бохирдол 88.4 хувьд хүрчээ

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Нийслэлийн хөрсөнд буй органик бохирдол нь хотын хүн амын 59 хувь буюу 218 мянган айл өрхийн 200 гаруй нүхэн жорлон, 140 мянга гаруй угаадасны нүх, гэр хорооллын дунд бий болсон хог хаягдлаас үүдэлтэй аж. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын агаарын бохирдол төдийгүй хөрсний бохирдол их хэмжээгээр нэмэгдэх болсон. Энэ нь нийслэлийн хүн амын төвлөрөл ихэссэнтэй холбоотой юм. Нийслэлийн хүн ам ихээр төвлөрөхтэй зэрэгцэн машин, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын тоо ч нэмэгдээд буй. Хөрсийг бохирдуулж байгаа эдгээр хүчин зүйлээс гадна иргэдийн ухамсрын асуудал хөндөгдөж байна. Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын хувьд ахуйн болон үйлдвэрээс гарч буй хог хаягдлыг ангилж, дахин боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлээд нэлээдгүй хугацаа өнгөрсөн. Тодруулбал, Япон гэхэд Нефтийн хямралын үе буюу 1973, 1979 оноос эхлэн иргэд нь ухамсраараа хог хаягдлыг ангилж ялган, хаяж эхэлсэн. Үүний дараагаас 1991 оноос хуулиндаа хог хаягдлыг ялган ангилж хаях, дахин боловсруулах тухай нэмэлт өөрчлөлтийг оруулсан байдаг. Харин манай улсын хувьд хөрсийг халдваргүйжүүлэх, ариутгах тал дээр туршлага дутмаг бөгөөд мэргэжилтэн ч байгаа, эсэх нь эргэлзээтэй. Гэтэл хөрсний асуудлаа шийдвэрлээгүй байж дараагийн үе шат буюу ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, зүлэг, мод, цэцэгс тарихаа нэн тэргүүнд тавина.

Автомашины засвар, үйлчилгээний газруудыг цэгцлэнэ

Уг нь ногоон байгууламж байгуулах үндэс суурь нь эрүүл хөрс. Байгаль орчин төдийгүй нийслэлийн иргэдийн эрүүл мэндийн гол асуудал болсон хэдий ч орхигдоод байгаа хөрсний бохирдолд нийслэлийн ИТХ дахь АН-ын бүлгээс анхаарал хандуулж ажиллахаар БОАЖЯ, ХӨСҮТ, нийслэлийн Эрүүл мэндийн үндэсний төв болон нийслэлийн харьяа байгууллагууд, их дээд сургуулийн эрдэмтэн, судлаачидтай өчигдөр уулзаж хэлэлцлээ. Эрдэмтэн судлаачдын хамгийн сүүлд хийсэн судалгаагаар газрын хөрснөөс авсан дээжийн 88 хувьд нь нян, мөөгөнцөр илэрч, худалдаа үйлчилгээний томоохон төвүүдийн орчимд шиветрийн бохирдол 88.4 хувьтай, сульфатын бохирдол 72 хувь гарчээ. Хэлэлцүүлэгт оролцож буй ХӨСҮТ-ийн эмч “Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хөрсний бохирдол 2-3 дахин нэмэгдсэн. Үүнээс болоод гар, хөл, амны өвчин, дизентрий, суулгалт зэрэг гэдэсний халдварт өвчин ихсэж байна. Тиймээс энэ их бохирдолтой байгаа үед бага насны хүүхдийг аль болох хөрснөөс хол байлгах хэрэгтэй” гэв. Түүнчлэн хортой хог хаягдлаас үүдэн хөрсөнд шингэсэн нян бактери нь тодорхой хугацаанд амьдарч байдаг



Б.Ганбаяр / ЗГМӨ

болохоор эргээд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэж НЭМҮТ-ийн мэргэжилтэн хэллээ. Мөн УСУГ-ын дарга Ц.Төрхүү “2011 онд Усны тухай хууль гарсан хэдий ч журам нь одоо хүртэл гараагүй л байна. Гэтэл өнөөдөр усны бохирдол 10 хувиар нэмэгдчихсэн. Ундны усны асуудалд зайлшгүй анхаарч, үйлчилгээ явуулдаг байгууллага, үйлдвэрүүд дэргэдээ цэвэршүүлэх байгууламжтай болох шаардлагатай байна” гэдгийг хэлсэн юм.

Энэ мэтчилэн хэлэлцүүлэгт оролцсон албан байгууллагууд өөр өөрсдийн байр сууриа илэрхийллээ. Хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ болон хийгдэх шаардлагатай ажлын талаар НИТХ-ын төлөөлөгч Т.Батцогтоос тодрууллаа.

-Сүүлийн үед нийслэлийн хөрсний бохирдолд төдийлэн анхаарал хандуулахаа больсон. Ногоон байгууламжийн бааз суурь болсон орхигдоод байгаа энэ асуудалд хэрхэн анхаарч ажиллах вэ?

-Энэ оны нэгдүгээр сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаж агаарын бохирдол, хөрсний бохирдол өндөр түвшинд хүрсэн талаар яригдсан. Тиймээс хөрсний бохирдолд анхаарч ажиллах цаг болжээ. Жил бүрийн дөрөвдүгээр сар буюу дулааны улирал эхлэхтэй холбогдуулан хөрсний бохирдолд анхаарлаа хандуулдаг болох хэрэгтэй. 2014, 2015 онд гэр хорооллын дахин төлөвлөлтийн үр дүнд хөрсний бохирдол тодорхой хэмжээгээр буурч байсан. Гэтэл өнөөдөр нийслэлийн хөрсийг ахуйн хэрэглээний жорлон, угаадас, үнс зэрэг органик бохирдол болон автомашины тос, масло, үйлдвэрийн гаралтай химийн хог хаягдал бохирдуулж байна. Тиймээс эхний ээлжинд хөрсийг ариутгах, халдваргүйжүүлэх шаардлагатай. Дараа нь нэмж бохирдуулахгүй байх, нөхөн сэргээх, ногоон байгууламж байгуулах зэрэг арга хэмжээ авч ажиллана. Түүнчлэн тоо томшгүй олширсон автомашины засвар, үйлчилгээний газруудыг цэгцлэх болно.

-Хөрсийг бохирдуулж буй гол хүчин зүйл нь хог хаягдал байдаг. Иймээс үүнд хэрхэн анхаарал хандуулж байна вэ?

-Өнгөрсөн жилүүдэд Баянзүрх

дүүргийн 14 дүгээр хороо Нарантуул захын хойд талын хэсэг хөрсний органик болон нянгийн бохирдол маш ихтэй байсан. Харин 2014, 2015 онд гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил эхэлснээр дээрх хэсгийн бохирдол буурсан. Одоо хэрэгжүүлэх боломжтой арга нь нийслэлд байгаа хогийн цэгүүдийн хогийг булж устгахгүйгээр дахин боловсруулах юм. Зардал ихтэй боловч маш үр дүнтэй. Яг одоогийн байдлаар Цагаан давааны хогийн цэгт Дахин боловсруулах үйлдвэр байгуулах БНСУ-ын 150 сая ам.долларын хөрөнгө оруулалттай томоохон төсөл хэрэгжээд зураг төслийн шатанд явж байна. Магадгүй ирэх жилээс барилгын ажил эхэлнэ гэж найдаж байгаа. Энэхүү хог хаягдал нь Улаанбаатар хотын зүүн хэсгийн хог хаягдлыг бүрэн боловсруулах боломжтой гэж харж байна.

-Гаднын туршлагаас харахад хогоо ангилж хаядаг. Гэтэл манайд энэ байдал эсрэгээрээ. Энэ талаар та ямар баарь суурьтай байна вэ?

-Энэ бол ухамсрын асуудал. Тиймээс бага ангид байхаас нь эхлээд хог хаягдлыг ангилж сургах болон орчноо эрүүл, цэвэрхэн байлгах боловсрол олгоход анхаарч, тусдаа програм гаргах ёстой. Нэг үеэ бодвол нийгэм их өөр болсныг хүмүүст таниулаад, ойлгуулаад хэрэглээнд хэвшүүлээд эхэлбэл хүмүүсийн ухамсар өөрчлөгдөнө гэлээ.

Хөрсний бохирдол үүсгэж, иргэдийн эрүүл мэндэд шууд бус замаар нөлөөлж буй химийн бохирдолтой үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд, авто засвар, угаалгын газар, арьс ширний үйлдвэрүүдийн газруудын үйл ажиллагааг журамлах, үйлчилгээний олон улсын жишигт нийцэхүйц стандартыг боловсруулж, мөрдөх журам зэргийг боловсруулан УИХ, Засгийн газар, нийслэлийн ИТХ зэрэг холбогдох шат шатны төрлийн байгууллагад хүргүүлэхээр боллоо. Нийслэл хотын иргэдийн эрүүл мэндэд заналхийлээд байгаа хөрсний бохирдлыг бууруулахад дээд албан тушаалтан, байгууллага бус хувь хүний оролцоо маш чухал. Тиймээс газраар дамжин таны эрүүл мэндийг чимээгүй хохиروож байгаа хөрсний бохирдолд анхаарах цаг болжээ. [ЗГМ]

ДҮҮРЭГ

Усны хоолойн хугацаа хэтэрчээ

Улаанбаатар хотын ундны усны Налайх дүүрэг дэх шугамд бямба гарагт гэмтэл гарч, өндөр даралтаар ус алдсан. Үүний шалтгаан нь бүс нутгийн орчим рашаан булаг олонтойгоос газар гэсэх, хөлдөх үеэр шугамын тохиргоо алдагдаж, хөдөлгөөн ордогтой холбоотой болохыг УСУГ-ын мэргэжилтнүүд хэллээ. Гэмтэл гарсан ган шугамыг 1988-1989 онд ашиглалтад оруул-

сан ба эл шугамын эдэлгээний хугацаа 40-50 жил аж. Цэвэр усны ган шугамд гарсан уг гэмтлийг өнөөдрийн байдлаар бүрэн засварлаж дуусчээ. Мэргэжилтнүүдийн хэлж буйгаар хоолойд гарсан гэмтлийг засварлах хугацаанд нийслэлийн цэвэр усны хангамжид саатал учруулаагүй бөгөөд шугамыг хэсэгчлэн хааж, нөөц шугамаа ашиглан ус түгээсэн гэв. [ЗГМ]

БОЛОВСРОЛ

Мэргэжлийн дадлага, туршлагыг илүү ойртууллаа

ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль Япон Улсын “Mitsubishi Electric” корпорацийн шинэ лабораторитой боллоо. Тус лаборатори “Сэцүёо Астек” корпорацийн хандиваар байгуулагдаж байгаа аж. Хандиваар хамгийн сүүлийн үеийн өндөр хурдтай, мэдрэгч дэлгэц бүхий “FX3G-40MT/ES-A” загварын 15 иж бүрдэл, “Melservo JN A” загварын хөдөлгүүрийн удирдлагын хоёр иж бүрдэл төхөөрөмж зэрэг нийт 750 гаруй мянган иенийн үнэ бүхий тоног

төхөөрөмжийг хүлээлгэн өгчээ.

ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн захирал Ч.Мангал-жалав “Автоматжуулсан систем маш хурдтай хөгжиж байгаа үед бид шинэ техник, технологи нэвтрүүлэхгүй бол “Оюу толгой”, “Эрдэнэт”, “ТЭЦ-4” зэрэг томоохон үйлдвэрийн газар оюутнуудаа ажиллуулахад маш бэрхшээл тулгардаг. Харин тус лабораторитой болсноор манай оюутнууд орчин үеийн технологи практик дадлага хийх боломжтой болж байна” гэв. [ЗГМ]

Төгсөлтийн баярыг хазаарлана

Жил болгоны хаврын улиралд нийслэл хотын ресторлан, баар, олон нийтийн газрууд төгсөгчдийн хөл хөдөлгөөнөөр тасардаггүй. Өргөн дэлгэр тэмдэглэдэг энэхүү арга хэмжээг хазаарлах шаардлагатай байгааг урьд жилүүдийн туршлагаас харж болно. Тэгвэл Ерөнхий боловсролын сургуулийн болон их, дээд сургуулийн төгсөгчдийг төгсгөлтийн баяраа “Эрдмийн баяр” болгон зохион байгуулахыг БСНУС-ын сайд үүрэг бол-

голоо. Уг шийдвэрийг бүх шатны сургалтын боловсролын байгууллагын захирал, эрхлэгч нарт хүргүүлсэн байна. Тушаалд “Эрдмийн баяр” тэмдэглэх нэрээр төгсөгчдөөс хуульд заагаагүй төлбөр, хураамж авах, хөдөө хээр, амралт зуслан, голын сав, жуулчны бааз, зочид буудал, цэнгээний газруудад зохион байгуулах, архи, согтууруулах ундаа хэрэглүүлэхийг хатуу хоригложээ. [ЗГМ]

CHARLIE ROSE

ЖЕФФ БЕЗОС

“Чарли Роуз” нэвтрүүлгээр 1994 онд граж дотор анх цахим номын дэлгүүр нээж, улмаар одоогийн Амазоныг үүсгэн байгуулсан Жефф Безостой ярилцах болно. Амазон өнөөдөр дэлхийн хамгийн өндөр үнэлгээтэй компаниудын нэг болж, эзэн нь дэлхийн хамгийн баян хүмүүсийн жагсаалтад Бил Гейтсийн дараа бичигдэж байна.

“Бүхнийг бүгдэд зарах” зорилготой Амазоны цар хүрээ жижиглэнгийн худалдаанаас хэдийн давж, Amazon web services нь Cloud-д суурилсан тэргүүлэгч компани болжээ.

Мягмар гараг /2017.04.25/

14:00

13:00 Бямба гараг /давталт/

22:00 Ням гараг /давталт/

Bloomberg TV Mongolia

Лавлах

БОЛОВСРОЛ

Улсын шалгалтын жишиг даалгавар

Б.Баярмаа
ЗГМ

Ерөнхий боловсролын сургуулийн 5, 9, 12 дугаар ангийн сурагчдаас авдаг улсын шалгалтын хуваарь гарлаа. Тавдугаар ангийн сурагчид ирэх сарын 22-29, есдүгээр ангийнхан ирэх сарын 25-30, төгсөх ангийнхан ирэх сарын 24-29-нд шалгат өгөх юм байна. Боловсролын үнэлгээний төвөөс улсын шалгалтад бэлдэж буй сурагчдад зориулан 2015, 2016 онд авсан шалгалтын жишиг даалгаврыг цахим хуудастаа нийтэллээ. Нийт 11 хичээлийн 15 жишиг даалгавар, түлхүүр үгтэй <http://ees.mn> хаягаар орж танилцаарай.

Улсын шалгалтын бүтэц нь тест, задгай даалгавар хосолсон хэлбэртэй бөгөөд “Цөм” хөтөлбөрийн агуулгад нийцсэн байх аж. [ЗГМ]

ТАТВАР

Урлагийнхнаас татвар авна

Нийслэлийн нутаг дэвсгэрт урлагийн тоглолт, арга хэмжээ зохион байгуулж буй хувь хүн, аж ахуйн нэгжүүдийг бүртгэж, Нэмэгдсэн өртгийн албан татварт хамруулахаар боллоо. Ирэх зургадугаар сарын 1-нээс тоглолтын тасалбар худалдаж авсан иргэд бусад бараа, үйлчилгээнийхтэй ижил сугалаа бүхий төлбөрийн баримт авдаг болох юм.

Ингэснээр нийслэлийн татварын орлого тодорхой хэмжээгээр нэмэгдэхээс гадна үйлчилгээний байгууллагуудын тэгш байдлыг хангана гэж Татварын ерөнхий газраас үзжээ. Энэ шийдвэрийг хэрэгжүүлэхдээ нийслэлийн Соёл урлагийн газартай хамтрах юм байна. [ЗГМ]

ҮЗЭСГЭЛЭН

Баримтат гэрэл зураг сонирхоорой

Баримтат гэрэл зургийн “Хүмүүс-6” үзэсгэлэн энэ сарын 26-нд нээлтээ хийнэ. Уг үзэсгэлэнг “Гамма” агентлаг, “Батзориг” сангаас зургаа дахь жилдээ зохион байгуулж байна. “Хүмүүс-6” үзэсгэлэнд 2016-2017 онд авсан ахуй амьдрал, хүмүүс, хөрөг, байгаль, үйл явдал, нийгмийн тулгамдсан асуудлууд зэрэг сэдвийн хүрээнд 80 гаруй зурагчны 600 гаруй бүтээл иржээ. Эдгээрээс шилдэг 40-ийг шүүгчдийн саналаар шалгаруулж, “Хүнүү малл” төв дэх “Гамма галерей”-д дэлгэх юм байна. Шүүгчээр “Батзориг” сангийн тэргүүн Ц.Очгэрэл, гэрэл зургийн редактор Л.Элбэгзаяа, С.Туяа, Япон улсын гэрэл зурагчин Тецуро Шимизү нарын мэргэжлийнхэн ажиллажээ. [ЗГМ]

ЗАГВАР

“Гудамжны” загварын шоу болно

Залууст зориулсан street-style буюу чөлөөт хэв маягийн хувцасны “Urban nomads” загварын шоу энэ сарын 29-нд “One event hall”-д болно. Дэлхийд танигдсан алдартай брэндийн хувцас, хэрэглэлүүдийг хэрхэн зохицуулж өмсөх талаар шинэлэг, сонирхолтой санаануудыг эндээс сонирхоорой. Шоуны тайзнаа мэргэжлийн загвар өмсөгчдөөс гадна жүжигчид, дуучид гээд олны танил залуус алхах аж. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР				
	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	07.00 “Монголын шинэ өглөө” хөтөлбөр	07.00 “Чарли Роуз-Жефф Безостой ярилцсан нь” нэвтрүүлэг	09.45 “Би Монгол хүн” нэвтрүүлэг	09.30 “Тог тог тог” хүүхдийн нэвтрүүлэг
12.00	10.15 “Төл таван эрдэнэ”	12.00 “Бизнесийн хэмнэл” давталт	11.15 “Тамирын багш” ОАК 20-21 дүгээр анги	12.00 “Хөтөч” мэдээллийн хөтөлбөр
14.00	14.30 “Нууц шифрийн учир” ОАК 3-4 дүгээр анги	15.00 “Бизнесийн төв цэг” хөтөлбөр	14.10 Хүрэлэн” цуврал нэвтрүүлэг	15.00 “Өөрчлөлт” гуравдугаар бүлэг, 22 дугаар хэсэг
18.00	16.30 “Робокон 2017”	17.00 “Bloomberg Surveillance” нэвтрүүлэг	18.35 “Дэлхийн атлас” нэвтрүүлэг	19.30 “Ороод гараач” нэвтрүүлэг тав дугаар хэсэг
20.00	19.10 “Урлаг” теле сэтгүүл	20.30 “Сайн уу, дэлхий” нэвтрүүлэг	21.00 “Зөв үнийг таа” шоу нэвтрүүлэг	20.00 “Оргил цаг” мэдээллийн хөтөлбөр
22.00	21.05 “Цаг үе, үзэл бодол”	21.00 “Мөнгөний урсгал” хөтөлбөр	22.00 “Хайр эргэсэн хавар” ОАК 21 дүгээр анги	00.05 “Орголт” ОАК 18 дугаар анги

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1.АНУ-ын төрийн тэргүүнээр хамгийн олон жил ажилласан хүн

5.Далайн аялалд хүчирхэг байж, газарзүйн шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан улс

10. Төрийн дээд шагнал

11.Залгамж баялаг

12. Маш, тун гэсэн үг

14. Үл мэдэгдэх тоо (дуудлагаар нь)

15. Машин техникийг зогсоох механизм

16. Хөөргөний үнэт чулуу

17. Цондон

БОСООГООР:

1.Өнгөт арьстнуудаас үүсэлтэй бүжиг

2.Эмэгчин бор гөрөөс

3.Таних тэмдэг, бэлгэдэл

4.Хэвлэл,

мэдээллийн чухал хэрэгсэл

6.Малд тарга тэвээрэг авахуулах шилдэг арга

7.Казахууд отгон хүүдээ өвлүүлэн үлдээдэг зүйл

8.Хойд ба Латин Америкийг заагладаг суваг

9.Нохойны нэр

13. Цахилгаан хэлхээний үндсэн хуулийг нээсэн эрдэмтэн

ХӨНДЛӨНГӨӨР:

Э Б С

З Х У

Э А Р И Н Х У У Р

Э Т Я Ч Г

Э А М И Ө

Л Х А М С Ү Р Э Н

У

Ц У У Р Х А Л

Я Э Я

Б А Я Н А Г Т

Өмнөх дугаарын хариу 04,24

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

IV.25

10° | 12 м/с
-5° | 7 м/с

Үүлшинэ

IV.26

13° | 12 м/с
-4° | 10 м/с

Үүлшинэ

IV.27

20° | 17°
-1° | 7 м/с

Багавтар үүлтэй

IV.28

20° | 7 м/с
2° | 6 м/с

Багавтар үүлтэй

IV.29

13° | 7 м/с
-1° | 5 м/с

Багавтар үүлтэй

Орхон 15° 0°

Дархан-Уул 18° 2°

Сэлэнгэ 11° -2°

Булган 10° -5°

Хөвсгөл 12° -2°

Увс 17° -1°

Ховд 17° 0°

Завхан 12° -5°

Архангай 12° -2°

Төв 10° -4°

Хэнтий 13° -3°

Дорнод 15° -0°

Сүхбаатар 15° -2°

Говь-Сүмбэр 16° -3°

Дундговь 16° -3°

Дорноговь 19° -2°

Өмнөговь 17° 0°

Баянхонгор 14° -3

Өвөрхангай 14° -1

Говь-Алтай 11° -5°

Баян-Өлгий 15° -1°

[ЗГМ]

“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ”
СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

“ZGM-FINANCIAL TIMES-NYT”
ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД
5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ
СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ,
СУРВАЛЖЛАГАТАЙ
ХОЛБООТОЙ САНАЛ
ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн **ПАЯН**

[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ]

Таны хундага хоосорчихож, дахиж нэгийг захих уу?

Би тэгээд хоёр хоосон хундагаар яах юм?

NOMADIC COMICS

ОНЦЛОХ ҮЗВЭР

“Лемонс” цомгийн баяраа хийнэ

Амьд хөгжмийн “Лемонс” хамтлаг ирэх сарын 5-нд шинэ цомгийн баяраа хийх гэж байна. “Un-plugged in UB” нь тус хамтлагийн дөрөв дэх бие даасан цомог юм. “Corporate” зочид буудлын Con-vention танхимд болох тоглолтод “Булсара”, “Нисванис”, “Шөнийн галт тэрэг”, “A sound” зэрэг амьд хөгжмийн хамтлагууд урилгаар оролцох юм байна. Тоглолтын дараах үдэшлэгт тасалбар худалдан авсан үзэгчид 50 хувийн хөнгөлөлттэй оролцох боломжтой. “Лемонс” хамтлаг нь байгуулагдаад 13 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд “Red album”, “Залуу Лениний ойролцоо гурван давхарт”, “III” гэсэн цомгууд гаргасан юм. [ЗГМ]

ЗГМ: СҮДОКУ

			1				4
			9	8	6		
7	1	5					
3	9	7					
					8		
		1	6	7	3		5
8			6	4		1	
1	5			2		8	
	3			5			

6	8	2	4	7	9	5	3	1
3	9	5	6	1	8	2	7	4
7	1	4	5	2	3	9	8	6
8	7	6	2	5	4	3	1	9
1	5	3	8	9	6	4	2	7
4	2	9	1	3	7	8	6	5
9	4	8	7	6	2	1	5	3
2	6	1	3	4	5	7	9	8
5	3	7	9	8	1	6	4	2

(Өмнөх дугаарын хариу)

ҮЗВЭР

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН

Олон улсын жазз хөгжмийн өдөрт зориулсан “The jazz train” хамтлагийн тоглолт энэ сарын 30-нд 17.00 цагт болно. Тоглолтын тасалбар 30 мянган төгрөгийн үнэтэй.

UB PALACE

“Харанга”, “Хурд”, “Нисванис”, “Чоно”, “Никитон” хамтлагийн хамтарсан “Мартагдашгүй” тоглолт энэ сарын 28-нд 19.00 цагт тоглоно.

МИШЭЭЛ ЭКСПО

“Барилга экспо” үзэсгэлэн энэ сарын 28-30-нд болно. Үзэсгэлэнгийн үеэр барилгын материалын хямдралтай худалдаа явагдана. Мөн шинээр баригдсан орон сууцуудын талаарх мэдээллийг авах боломжтой.

БИШРЭЛТ ЗОЧИД БУУДАЛ

Япон, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойд зориулсан “Tokyo night” арга хэмжээ энэ сарын 28-нд болно.

УДБЭТ

П.И. Чайковскийн бүтээл “Нойрссон гүнж” бүжгэн жүжиг энэ сарын 29-нд 17.00 цагт болно.

УЛСЫН ФИЛАРМОНИ

Симфони найрал хөгжмийн 60 жилийн ойд зориулсан “Алтан өргөө” Монголын кино хөгжмийн бүтээлийн нэгдсэн концертыг энэ сарын 27-нд 19.00 цагт толилуулна.

ONE EVENT HALL

Төв аймгийн Сүмбэр сүмийн өрх толгойлсон эмэгтэй Н.Лхагвасүрэнд туслах зорилготой “М2М” хандивын тоглолтыг Дэлхийн зөн байгууллагаас зохион байгуулна. Энэ сарын 27-нд болох уг тоглолтод рок попын залуу уран бүтээлчид оролцох юм.

ЗУРХАЙ

Билгийн тооллын 29

Хаврын дунд харагчин туулай сарын дөрвөн ногоон мэнгэтэй хар морь өдөр.

Үс засуулбал. Сүлд тэнэж одно.

Наран ургах, шингэх. 05.48-19.57

Барилдлага. Үхэх

Шүтэн барилдлага. Өтлөх үхэхүй

Суудал: Мод

Аргын тооллын дөрөвдүгээр сарын 25. Ангараг гараг. Билгийн тооллын 29. Дэлгэрүүлэгч одтой, хар морь өдөр.

Өдрийн наран 05.48 цагт мандан, 19.57 цагт жаргана. Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лусыг тахих, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэтвэйт газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ГАЛТ ТЭЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ		
Москва-УБ	23.45	06.50
УБ-Москва	15.22	13.58
УБ-Дархан	09.30	13.30
Дархан-УБ	14.15	18.43
УБ-Эрдэнэт	20.35	07.35
Эрдэнэт-УБ	18.35	05.45
УБ-Шарын гол	20.40	06.30
Шарын гол-УБ	19.50	05.50
УБ-Замын-Үүд	17.20	07.20
Замын-Үүд-УБ	18.05	08.45

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ		
УБ-Сөүл	08.45	12.50
Сөүл-УБ	14.20	16.50
Хонконг-УБ	12.05	16.45
УБ-Хонконг	06.25	10.55
УБ-Ханбумбат	07.20	08.30
Ханбумбат-УБ	09.20	10.25
УБ-Бээжин	17.55	20.10
Бээжин-УБ	21.10	23.40

Дүрвэгсэд зовлон зүдгүүрээ урлагаар илэрхийлжээ

Тэмцэж буй үедээ амьд гэдгээ мэдэрдэг” хэмээн өгүүлжээ. > 10

Тэтгэврийг сүүлийн цалингаас тооцохыг зогсоов

Royal Mail компанийн ажилчид мөн тогтсон тэтгэвэрийг хассаны учир хөдөлмөрийн маргаан үүсгэжээ. > 10

Япон Номхон далайн түншлэлийг сэргээнэ

Гэвч хэд хэдэн хүчин зүйл Японыг санаагаа өөрчлөхөд хүргэсэн бололтой.> 10

Сонгуулийн эхний шат Макроны ялалтаар өндөрлөв

Нидерландад гуравдугаар сард хэт барууныхныг буланд шахсан сонгууль, есдүгээр сард Германд баруун төвийн юм уу зүүн төвийн аядуу үзэлтнүүд ялах төлөвтэй нөхцөл зэргийг харгалзан үзвэл Европын либерал ардчилал, Европын холбооны төлөө гашуудах нь хэт эртэдсэн хэрэг.

Юутай ч сонгуулийн эхний шатны дүн 1958 онд Шарль де Голль анх Францад тогтоосон улс төрийн системд гэнэтийн цохилт боллоо. Франц орны сүүлийн 50 жилийн түүхэнд зүүн, барууны байр суурьтай улс төрийн гол хүчнээс нэр дэвшигч нар бүгдээрээ Ерөнхийлөгчийн сонгуульд ялагдал хүлээж байсан удаагүй. Тавдугаар бүгд найрамдах улсын намуудын тогтолцоо харсаар байтал нүдний өмнө сүйрч байна.

Гэхдээ ноён Макроныг тэс хөндлөнгийн өрсөлдөгч болгон дүрслэх нь ташаа хэрэг. Хэрэг дээрээ тэрбээр намын хуучин тогтолцоо сүйрч буйг хэдэн жилийн өмнөөс ухамсарлан, сонгогчдод цоо шинэ нэр дэвшигч танилцуулах эрэлд мордсон Францын технократ улс төрийн элитүүдийн



BBM©

хүрээнээс тодорч байгаа юм. Ноён Макрон бол Францын элитүүдийг бэлтгэдэг École Nationale d'Administration зэрэг тус улсын боловсролын шилдэг байгууллагын бүтээгдэхүүн. Тэрбээр халаагаа өгөх гэж буй Ерөнхийлөгч Франсуа Олландын зөвлөх, Эдийн засгийн сайд зэрэг

алба хашиж байлаа.

Ноён Макрон тавдугаар сарын 7-нд яллаа ч засаглах үйлс нь хүнд байх болно. Түүний байгуулсан шинэхэн En Marche! намаас нэр дэвшигчид одоогийн улс төрийн уур амьсгалд дулдуйдан, зургадугаар сард болох парламентын

сонгуульд цөөнгүй суудал авч магадгүй ч үнэмлэхүй олонх болох аргагүй. Ноён Макроныг дэмждэг, төвч байр суурьтай “Ерөнхийлөгчийн бүлэглэл”-намаас нэр дэвшигчид одоогийн улс төрийн уур амьсгалд дулдуйдан, зургадугаар сард болох парламентын

хүсэх нь л байж болох хамгийн үнэмшилтэй зураглал.

Энэ нь уламжлалт зүүн, барууны хүчин өрсөлдөн тэмцэж ирсэн түүхтэй Франц орны ээ шүүмжлэн өөнтөглөгч хэт баруун, консерватив баруун, зүүний хүчнийхнийг багтаасан хууль тогтоох байгууллага

амьсгалыг үлдэн хөөж, эдийн засгийн сүр хүчийг дахин сэргээх шинэчлэлээ өрнүүлэх гэвэл хатуу яриа хэлэлцээ өрнүүлж, эвслийн Засгийн газар бүрдүүлэхээс аргагүй бололтой.

Францын орны гудамж талбайд ч түүнийг эсэргүүцэгчид бий. Эхний шатанд оролцсон франц сонгогчдын 40 гаруй хувь хатагтай Ле Пен юм уу, хэт зүүний байр суурьтай Жан-Люк Меланшоны төлөө саналаа өгсөн явдал үүний баталгаа. Гэтэл 2012 онд болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатанд энэ хоёр эрхмийн төлөө нийт сонгогчдын 29 хувь нь санал өгч байсан юм.

Эдүгээ ноён Макрон шинэчлэлээ хэр дайчин өрнүүлэхээс бүх зүйл шалтгаална. Шинэчлэлээ хэр гүнзгий өрнүүлэх талаар тодорхой тайлбарласангүй хэмээн түүнийг сонгуулийн кампанийн үеэр шүүмжилж байсан удаатай. Ноён Макрон Франц орны бизнесийн орчныг илүү өрсөлдөх чадвартай болгоно гэх мөртлөө нийгмийн халамжийг сайжруулах тухай ярьдаг. Тэрбээр хүн бүхэнд л нэг юм амлаад байгаагаа томьёолж буйн илрэл болох “en pleine temp” буюу “үүний зэрэгцээ” гэсэн утгатай үгийг яриандаа хэрэглэх дуртай нь тохиолдлын хэрэг бус.

Энэ хүний засаглал ноён Олланд, Николя Саркозигийн шиг доройтох эсэх нь 2022 онд болох Ерөнхийлөгчийн сонгуулиар хатагтай Ле Пен юм уу, оршин буй тогтолцоог эсэргүүцэгч өөр бусад хүчин эрх мэдэлд хэр санаархааас шалтгаална.



Хятадын экспортлогчид-Глобалчлалын цэргүүд

Бэн Бланд

Аялах дуртай юу? Аялах бүртээ чөмөдөн чирсээр залхаа юу? Тэгвэл цахилгаан хөдөлгүүртэй скутер болдог чөмөданыг бөөний үнэ болох 250 ам.доллараар ав. Захиалга авах доод хэмжээ нэг чингэлэг.

Гуанжоу хотноо болдог Хятадын худалдааны хамгийн том яармагт тавигдсан энэхүү бүтээгдэхүүн өнөө үед бас нэг Ford Model T болж чадах нь юу л бол. Гэхдээ л энэ бараа нь Хятад үйлдвэрлэгчдийн бүтээлч урам зориг юутай ихийг Европ, АНУ, Латин Америкийн худалдан авагчдад харуулж байгаа юм.

БНХАУ-ын дарга Ши Жиньпин нэгдүгээр сард Давост болсон чуулга уулзалтад эдийн засгийн глобалчлалыг хамгаалагчийн үүрэгтэй оролцсон. Хятадын эрх баригчдын байр суурь нь хэрэгжүүлж хараахан амжаагүй протекционизмыг сурталчлагч АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын байр сууриас эрс ялгаатай.

Өрнөдийн тайлбарлагчид алга ташин дэмжиж байсан ч ноён Ши чөлөөт худалдааны бэлгэ тэмдэг болоход төдийлэн тохирдоггүй. Ши Жиньпин бол Хятадын эдийн засагт төрийн хяналтыг чангатгаж, гадаадын хөрөнгө оруулагчдын орчныг хүндрүүлж буй нэгэн.

Харин БНХАУ-ын 20 мянган үйлдвэрлэгч Гуандун мужид хоёр жил тутамд болдог яармагт оролцож буй гадаадын 200 мянган зочинд бүтээгдэхүүнээ сурталчилж байгааг л глобалчлалын илүү ухаалаг сурталчилгаа гэлтэй.

Хятад улс бол бэлэн бүтээгдэхүүний дэлхийн хамгийн аварга үйлдвэрлэгч. Худалдааны яармагийн үй олон асарт угаалгын өрөөний хэрэгслээс ухаалаг утас хүртэл бүх юм өрөөстэй. Үзэсгэлэнд бараагаа сурталчлагчдын зарим нь төрийн өмчийн компани. Ийм компани бүгд л төрийн хөнгөлөлт дэмжлэгтэй

ажилладаг. Ямар ч байлаа гэсэн Хятадын үйлдвэрлэгчид нь бүтээгдэхүүнээ борлуулах глобал эрэлт шаардлагын төлөө ажиллаж, амьдарч буй хүмүүс.

Ийм ч учраас борлуулалтын менежерүүд англи хэл сурч, техникч нар нь зардал хэмнэж, үйлдвэрлэлийн хугацааг богиносгох үүднээс угсрах шугамаа шинэчлэн, бүтээгдэхүүн хөгжүүлэх багийнхан үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бараа бүтээхээр хичээн зүтгэж байна.

Хятад оронд сүүлийн арван жилд цалин хөлс, үйлдвэрлэлийн зардал эрс өссөн нь үйлдвэрлэгчдийг бүр ч гүйлгээ ухаантай болгов. Компаниуд үйлдвэрлэлийн робот өргөн ашиглах болж, Amazon зэрэг шаламгай жижиглэн худалдаачдаас тавьдаг шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүнээ экспортд гаргах ч хурдан нийлүүлж, судалгаа, хөгжүүлэлтийн ажилд улам анхаарч байна.

Гуандуны үзэсгэлэн яармагт та таваарын үнэ унаснаас хойш чөмөдөн үйлдвэрлэгч болох хувирсан хөнгөн цагаан боловсруулалт, hoverboard хэмээх ганц болон хоёр дугуйт зугааны хэрэгсэл үйлдвэрлэх замаар дампуурахгүй тэсэж үлдэхээр хичээж буй цэцэрлэгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэгчтэй таарна. Дампуурч байгаа нь олон. Өөдөлж дэвжсэн нь бүр ч олон. Бараа бүтээгдэхүүнээ экспортд гаргах боломж нээлттэй байгаа нь л энэ олон үйлдвэрлэгчийн өрсөлдөх чадварт түлхэц өгдөг юм.

Эдийн засгийн өсөлт бүх салбарт удааширснаас дотоодын борлуулалт муудсан тул шүлтлэйн зай хураагуурын үйлдвэрлэлийн хятаддаа тэргүүлдэг Nanfu компани гадаад зах зээлээ тэлэхээр чармайж байна. Бүтээгдэхүүн нь чанарын хувьд Duracell, Energizer-тэй өрсөлдөж дөнгөхгүйг тус компанийн олон улсын бизнес

эрхэлсэн захирал Рассел Кон хүлээн зөвшөөрч байлаа. “Гэхдээ дээрх хоёрынх шиг бүтээгдэхүүнийг л дотоодын зах зээлд хэрэглээ болгочихвол бид ч бүтээгдэхүүнээ ижил түвшинд хүргэхээр чармайна” хэмээн тэрбээр тайлбарласан юм.

Дэлхийн эдийн засгийн орчин хүнд байгаа. Харин АНУ-ын эдийн засаг сэргэж, ноён Трамп протекционист арга хэмжээг далайцтай авахаа мэдэгдэж байна. Европ тивд эрэлт хэрэгцээ сул хэвээр. Хятадын өсөлтийн хурдац удааширмагц таваараас хамааралтай шинээр хөгжиж буй зах зээлд хэрэглээ хумигдав.

Сүүлийн жилүүдэд зардал өссөнтэй уялдан олон үйлдвэрлэгч, ялангуяа гутал, бэлэн хувцас зэрэг хөдөлмөрлөх хүч их шаарддаг үйлдвэрлэлээ Бангладеш зэрэг цалин багатай улсад шилжүүлсэн. Харин цахим хэрэгсэл, аж үйлдвэрийн машин механизм зэрэг салбарын үйлдвэрлэл улам бүр Хятадад төвлөрсөөр. Ханган нийлүүлэх найдвартай сүлжээ, ажиллах хүчний аварга хэмжээ, дэлхийн зах зээл дэх олон арван жилийн дадлага туршлага нь Хятад оронд эдгээр үйлдвэрлэл татагдах хүч болж өгчээ.

“Үйлдвэрлэлээ өөр улсад шилжүүлэх замаар цалин хөлстэй холбоотой зардлаа компаниуд хэмнэж болох. Гэхдээ жижиглэн худалдаа, таваарын үнэ өгсөж, уруудан янз бүр болдог нөхцөлийг үл харгалзан үйлдвэрлэлийг стандартын чанд шаардлагыг олон жил хатуу сахиж ирсэн түүхээр бидэнтэй өрсөлдөх улс байхгүй” хэмээн Hasbro зэрэг том компаниудын нийлүүлэгч, Хятадын тоглоомын үйлдвэрийн захирал тайлбарласан юм.

АНУ-ын Ерөнхийлөгч, БНХАУ-ын дарга хоёр юу ч гэж мэдэгдсэн, Хятадын экспортлогчид дэлхийн зах зээлд байр сууриа бэхжүүлсээр байх болно.



Майкл Пил

Эдийн засгийн өсөлт хурдасч, бүс нутгийн гааль татвар багассаны ачаар шинэ автомашины зах зээлд тэсрэлт үүсэж, Вьетнамын мотоцикль хөлөглөгч дундаж анги хоёр дугуйтаа дөрвөн дугуйт болгож эхэллээ.

Импортын татвар буурснаас хойш, Вьетнамын хотуудын бэлгэ тэмдэг болсон хоёр дугуйт унааны язганасан сүргийг седан автомашин, 4WD хөлгүүд шахах болов. Коммунист засаглалтай улсын 90 гаруй сая хүн ам унаагаа сольж байгаа нь эрх баригчдаас өнө удаан баримталж ирсэн бодлого албан ёсоор өөрчлөгдөж, иргэдийн амьдрал дээшилж буйн илрэл. Гэхдээ авто тээврийн салбарт энэ онд байдал тогтворгүй, засгийн бодлого тодорхой бус байгаа нь автомашинтай иргэдийг түгшээсээр.

Найдваргүй зээл, төрийн өмчийн компаниудын урагшгүй засаглал, хөдөө аж ахуйн зориулалттай газрыг талхин ашиглах явдал ноёрхсон, алдаатай менежмент үргэлжилсэн он жилүүд төгсгөл болж Вьетнамын эдийн засаг сая нэг зөв замдаа орлоо хэмээн Францын Natixis банкны ахлах эдийн засагч Трин Нгуен тайлбарлав. “Ногоон соёо болгон доороо сайхан үндэстэй байдаггүй. Үүнийг тооцоолохгүй бол Вьетнамын эдийн засаг боломжоо ашиглаж чадахгүй өнгөрнө” хэмээн хатагтай Нгуен өгүүлсэн юм.

Шинэ автомашины борлуулалт тус улсад далайцтай нэмэгдэж, өнгөрсөн онд 24, энэ оны эхний хоёр сард найман хувиар өссөнийг Вьетнамын автомашин үйлдвэрлэгчдийн холбооноос явуулсан судалгаа харууллаа. Хагас жилд багаан машин худалдаж авна хэмээн хариулсан хүмүүсийн тоо сүүлийн хоёр жилд эрс өссөнийг Financial Times-ийн судалгаа ч баталж байгаа.

Үнэ хямдарч, зээлийн нөхцөл



BBM©

сайжирсны ачаар төмөр хөлөг мөрөөдөх зүрхтэй болсон хүний нэг нь Ханойд ресторан ажиллуулдаг, 30 настай Нгуен Нам. “Аль эртнээс машин авахсан гэсэн бодолтойг хэлэх үү. Импортын татвар дахиж буурах сурагтай. Харзнадаг ч юм билүү” хэмээн ирэх онд автомашины гаалийн татварыг дахин бууруулах мэдээг дурдан байж тэрбээр тайлбарлав. “Найз нарын маань ихэнх нь ирэх жил авна гээд байгаа” хэмээн тэрбээр нэмж тайлбарласан юм.

Машины борлуулалт ихэссэн нь тус улсын эдийн засаг удтал завсарласны эцэст өнгөрсөн онд зургаан хувиар өсөж, бүс нутгийн хошуучлагчдын эгнээнд дахин байрлаа эзэлсний тусгал боллоо. Гэхдээ энэ оны эхний улирлын байдлаар эдийн засаг сүүлийн гурван жилийн үнэмлэхүй доод түвшинд буюу 5.1 хувийн өсөлттэй гарсан нь өсөлт тогтворгүйг харуулав.

Шинэ автомашины борлуулалт ч тогтворгүй байгаа нь зах зээлийн эмзэг байдлыг харуулж байна. Нэгдүгээр сарын борлуулалт жилийн өмнөх үеэс 13 хувиар өссөн. Харин хоёрдугаар сард борлуулалт жилийн өмнөхөөс шууд 50 хувиар нэмэгдсэнийг судалгааны материалд дурджээ.

Зах зээлд “тэсрэлт” үүссэн шалтгаан нь Вьетнам эгнээнд

нь багтдаг АСЕАН-ы улсууд хооронд автомашины импортын татварыг удаа дараа багасгасантай холбоотой. Индонезоос тус улсад экспортлох машины хэмжээ 2016 оны эхний гурван сард тэг үзүүлэлттэй байснаа энэ оны эхний гурван сард 3000 давж “харайлаа”. Мөн хугацаанд Тайландаас импортолсон машины тоо дөрөв дахин нэмэгдэж, 5700 давсан талаар Вьетнамын гаалийн байгууллага мэдээлэв.

Татвар багассанаас болж хохирогсод ч цөөнгүй. Ханой хотын Нгуен Ван Ку гудамжаас хуучин автомашины дэлгүүртэй Нгуен Трун Тан хүмүүс шинэ машин шохоорхох болсноос борлуулалт унасан талаар гомдоллов. Тэрбээр “шинэ нөхцөл хуучин машин импортлогчдод уришигтай” хэмээн өгүүлсэн юм.

Зүүн өмнөд Азийн бүс нутагт татвар бүхэлдээ багассан нь борлуулагчдаас шинэ машины нийцэл хямдруулахаас аргагүй нөхцөл үүсгэснийг шинэ Тоу-ота борлуулдаг өөр нэг дилер тайлбарлав. Үнэ хямдрал бүс нутагт үйлдвэрлээгүй шинэ машинд ч хамаатайг тэрбээр анхаарууллаа. “Надад лав хүнд байна. Машины үнийг хямдруулах гэвэл борлуулалтаас өөрт минь ноогддог комиссын шагнаалаа багасгахаас аргагүй” хэмээн дилер өгүүллээ.

Автомашины зах зээл шинээр хөгжиж буйтай уялдан Засгийн газар эдийн засгийн төлөвлөгөөгөө эргэцүүлэх шаардлагатай тулгарлаа. Импортын татварыг багасгаж дуусмагц, орон нутгийн автомашин үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг хамгаалах үүднээс бусад татварыг нэмж болзошгүй талаар эрх баригчид анхааруулж байна.

Чухам энэ нь Нгуен Нам шиг худалдан авагчдад одоо машин авах уу, эсвэл харзнаж байгаад мөнгөө хэмнэх үү гэсэн хүнд сонголт үүсгэжээ.



Тэтгэврийг сүүлийн цалингаас тооцохыг зогсоов

Майкл Пулер, Питер Кэмпбэлл

Jaguar Land Rover компани цалингийн сүүлийн дүнгээс ажилчдын тэтгэврийг тооцдог аргачлалаас татгалзсанаар өндөр настныхаа орлогыг танасан Британийн сүүлийн компани болов. Тус улсын үйлдвэрлэгч хамгийн том компани 7.1 тэрбум паундын хуримтлалтай боловч алдагдалд ороод байгаа тэтгэврийн сандаа шинэчлэл хийснээр хэдэн саяыг хэмнэхээр шийдвэрлэжээ. Тухайлбал цалингийн сүүлийн дүнгээс бус, ажилласан хугацааны дундаж цалингаар тэтгэврийн хэмжээг тооцох аргачлал нэвтрүүлэх юм. Sunday Times сонинд мэдээлснээр энэхүү арга хэмжээ нь хадгаламжийн хүү буурсантай холбоотойгоор компаниудын тэтгэврийн сангийн орлого

багассанаас үүдэлтэй аж. Хувийн салбарынхан өндөр настнууддаа орлогын боломжтой түвшинг хангадаг тэтгэвэр бодох аргачлалаа эргэн харахад хүрсэн байна. Иймээс шинэ аргаар тооцох үед ажиллагсдын хүлээх эрсдэл нэмэгдэж, тэтгэврийн хэмжээ буурах хандлага ажиглагджээ.

Энэтхэгийн ТАТА корпорацийн мэдэлд байдаг JLR компани жилдээ гурван тэрбум паундыг бүтээгдэхүүн ба капиталын хөрөнгө оруулалтад зарцуулдаг авч мөн хугацаанд тэтгэврийн зардлаа 224 саяар бууруулсан талаар эдний тайланд дурдсан байна. Түүнчлэн Британи дахь BMW-ийн мэдлийн үйлдвэрүүдэд тэтгэврийг багасгах шийдвэрийн улмаас ажил хаялт зарлаж, үйлдвэрлэл тасалдаж болзошгүй

нь. Шуудан холбооны Royal Mail компанийн ажилчид мөн тогтсон тэтгэврийг хассаны учир хөдөлмөрийн маргаан үүсгэжээ.

ТАТА-ийн хувьд ажилчид нь дээрх саналыг хүлээн авахыг зөвшөөрсөн тул хуучин 15 тэрбум паундын санг шинэ аргачлалаар бодох сан руу шилжүүлж, хуримтлалыг үргэлжлүүлэхээр шийдсэн байна. Port Talbot гангийн үйлдвэрийн захиргаа эрх баригчдад хандаж, Британийн гангийн үйлдвэрийн ажилчдын тэтгэврийн ерөнхий журмаас гарахыг санал болгов. Энэ журмаар цаашаа явбал тус компани төлбөрийн чадваргүй болно гэж анхааруулсан байна.

JLR компани Британид 42000 ажилчинтай ба үүнд туслан гүйцэтгэгчдийн ажиллах хүч багтдаг. Удаан ажилласан хүмүүс

сүүлийн цалингаас тооцох хуучин аргачлалд хамаардаг ба 2010 оноос хойш шинэ ажиллагсдыг уг санд бүртгэхээ зогсоосон боловч өмнө байсан хүмүүсийн хувьд тооцоолол өөрчлөгдөхгүй. Үүнээс гадна хуучин аргачлалд хамаардаггүй байнгын ажилчдын тэтгэврийг тооцох аргыг тусад нь авч үзэж сайжруулахыг санал болгосон аж.

2014 онд тэтгэврийн сангийн шинэчлэл яригдаж эхлэх үед Unite үйлдвэрчний эвлэл хариу арга хэмжээ авна хэмээн анхааруулж байсан. Unite-ийн үндэсний ажилтан Рожер Мэддисон нийт цалингаас тооцогдсон хуримтлал цаашдаа хадгалагдахыг нотолсон юм. Тэрээр “Бид JLR-тэй гэрээ байгуулаагүй боловч тэд үйлд-



вэрчний эвлэлтэй хэлэлцсэний дараа уг өөрчлөлтийг хийсэн. Эднийд 30-40 жил ажилласан хүмүүс банкинд хуримтлагдсан мөнгөө хадгалж үлдэж байгаа нь чухал” хэмээв.

2016 оны гуравдугаар сарын 31-нд дууссан санхүүгийн жилд JLR-ийн тэтгэврийн сангийн алдагдал 567 сая паунд

болж буурчээ. Тус компанийн төлөөлөгч “Бид тэтгэврийн сангийн тогтвортой байдлыг сайжруулахын зэрэгцээ хуучин аргачлалд хамаардаг хүмүүсийнхээ орлогыг таналгүй шинэчлэл хийхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргасан” хэмээн онцлов.



Дүрвэгсэд зовлон зүдгүүрээ урлагаар илэрхийлжээ

Жэми Смит

Австралийн дүрвэгсдийн лагерьт хоригдсон хүмүүс уран зохиол, хүүхэлдэй, киногоор зовлон зүдгүүрээ илэрхийлэхийг оролдож байна. Австралийн засаг захиргаа алслагдсан арлууд

дад байрлуулсан дүрвэгсдийн лагерьт хоригдож буй хүмүүсийн дуу хоолойг хаахын тулд боломжтой бүхнийг хийдэг. Гар утсыг хураах, сэтгүүлчдийг үл оруулах, ажилтнууд гадагш мэдээлэл өгвөл хорьж шийтгэх

мэтээр хатуурхана.

Гэвч Номхон далайн өмнөдөд Манус Науру аралд хашааны цаана буй дүрвэгсэд өгүүлэл, ном бичиж, хүүхэлдэйн болон бүрэн хэмжээний кино бүтээснээ гадагш нууцаар дамжуулах

аргаар зовлон зүдгүүрээ дэлхийн сонорт хүргэж байна. 2013 оноос хойш Папуа Шинэ Гвинейн Манус аралд хоригдож буй Бехруз Бучани “Бичих нь миний тэмцлийн зэвсэг. Тэмцэж буй үедээ амьд гэдгээ мэдэрдэг”

зодуулж нас барсан юм. Мануст хоёр дүрвэгч өвчний улмаас үхсэн баримт бий. Өнгөрсөн онд 23 настай Ираны орогнол хүсэгч НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн ажилтнуудын нүдэн дээр өөрийгөө шатааж,

Япон Номхон далайн түншлэлийг сэргээнэ

Робин Хардинг

Токио АНУ-ын оролцоогүйгээр Номхон далайн түншлэлийн хэлэлцээр (TPP)-ийг сэргээхэд бэлэн байгаа нь уг асуудлыг дахин амилуулах асар том боломж нээгдэж буйг харуулав. Японы албаныхны ярьснаар АНУ-ын ивээл дор хийгдэж байсан хэлэлцээрийн үг, үсгийг нэг их өөрчлөлгүй урагш ахиулах бодолтой байгаа аж. Өмнө нь Токио Америкийн машины зах зээлийг нээхгүй бол өөрийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний импортоо нэмэгдүүлж, фермерүүдээ хүндрэлд оруулахаас сэргийлж байв.

Дээрх шийдвэр АНУ-ын бус, хүнс экспортлогчид, тухайлбал Австралид томоохон давуу байдал олгох бөгөөд Азийн худалдааг хөгжүүлж, Хятадыг тойрсон бүс нутгийн эдийн засгийн түншлэлтэй өрсөлдөж магадгүй юм. Японы Худалдааны сайд Таро Асо Нью-Йоркт болсон уулзалтын үеэр ярихдаа “Бид тавдугаар сард болох Ази, Номхон далайн уулзалтын үеэр TPP-ийн гишүүн 11 (АНУ-г хасаад) улстай хэлэлцээг эх-

лүүлнэ” гэсэн бана. Түүнчлэн Австралийн Худалдааны сайд Стивен Чиобо өнгөрсөн долоо хоногт Токиод айлчилж, уг асуудлыг хэлэлцсэн билээ.

Дональд Трамп Цагаан оронд ирээд АНУ-ын Ерөнхийлөгчийн хувьд гарын үсэг зурсан анхны захирамжуудын нэг нь TPP-ээс гарах тухай шийдвэр байв. Үүний дараа Япон гэрээнд үлдсэн хамгийн том эдийн засаг болсон. Бусад 10 улсад Австрали, Бруней, Канад, Чили, Малайз, Мексик, Шинэ Зеланд, Перу, Сингапур, Вьетнам багтдаг. Австралийн тал гэрээг ямар ч байсан урагшлуулахыг хүссэн бол Ерөнхий сайд Шинзо Абэ Японы аж үйлдвэрийн бүтээгдэхүүний том зах зээл болох АНУ-гүйгээр утгагүй санаачилга гэж үзэж байв.

Гэвч хэд хэдэн хүчин зүйл Японыг санаагаа өөрчлөхөд хүргэсэн бололтой. Токио дахь бодлогын хүрээлэнгийн ахлах судлаач Кеничи Кавасаки юуны өмнө TPP Америкгүйгээр ч гэсэн Японд эдийн засгийн хувьд ашигтайг онцлоод “Бид чөлөөт худалдааны гэрээгүйгээр эдийн

засгаа сэргээхэд бэрх” гэжээ. Түүний хэлснээр тарифыг бууруулснаар Японы олох ашгийн гол нь АНУ-аас ирэх байсан агаад харин тарифын саад тогторгүй худалдааны ашиг Азийн түншүүдэд хамаарах аж.

Түүнчлэн геополитикийн давуу талууд бий. Уг гэрээ Японы бүс нутгийн гол түншүүд болох Австрали, Вьетнам улсуудтай харилцааг бэхжүүлнэ. Үүний зэрэгцээ оюуны өмчийн эрх болон Засгийн газрын худалдан авалтын талаар TPP-ийн хатуу журмыг хадгалах боломжтой. Ийм журам Япон, Хятад, Индонез, Филиппин зэрэг орныг багтаадаг RCEP буюу Бүс нутгийн эдийн засгийн өргөжүүлсэн гэрээний стандартыг дээшлүүлэхэд тустай гэнэ.

Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын дэд Ерөнхийлөгч Майк Пенс Токиод айлчлахдаа “TPP бол АНУ-ын хувьд өнгөрсөн зүйл” хэмээн мэдэгдсэн. Гэсэн хэдий ч Токио гэрээнд АНУ-ыг татан оролцуулах санаагаа орхиогүй байна. Ноён Кавасаки хэлэхдээ “TPP 11 багдалдахад худалдааны чиглэл өөрчлөгдсөнөөс АНУ



алдаж магадгүй” гэж тэмдэглэв. Тухайлбал, Австралийн үхрийн мах, Чилийн дарс Японы зах зээлд АНУ-ын өрсөлдөгчдөөс илүү байр суурьтай болох юм. Японы албаныхан Америкийн бизнесийн хүрээний хэн Вашингтоныг ятгаснаар Трампын үед биш юмаа гэхэд АНУ яваандаа TPP-д эргэн ирж магадгүй хэмээн найдаж буй. Ноён Кавасаки ярихдаа “Трампын хоёр талын худалдааг илүүд үзэж байгаа ч Японтой хийх шууд худалдаанаас олох ашиг

нь бага байж болзошгүй. Учир нь Япон АНУ-ын экспортод том байр эзэлдэггүй” гэж дурджээ. АНУ-гүйгээр TPP амьдрах чадвартай, эсэх нь эргэлзээтэй хэвээр. Ялангуяа, тарифыг бууруулсан тохиолдолд Вьетнам АНУ руу экспортлох нэхмэлийн бүтээгдэхүүнээсээ ашгаа нэмэх боломжтой байсан. Үүнгүйгээр тэд улсын компани, цахим арилжаа гэх мэт асуудлаар хатуу журамд нэгдэхээс түдгэлзэж болзошгүй юм.



амиа өгүүтгэсэн байна. “Завины хүмүүс”-ийн талаар 1970-аад онд боловсруулсан журам олон улсын зүгээс ихээхэн шүүмжлэл дагуулдаг. Австралийн тал энэхүү журмаа Индонезийн эргээс хэврэг завиар аялал хийж, далайд амиа алдахаас хүмүүсийг сэргийлдэг гэж үзсээр ирсэн.

Гэвч НҮБ ба хүний эрхийн байгууллагууд далайн гүн дэх лагерьт дүрвэгсдийг цоожлох нь хүнлэг бус явдал хэмээн шүүмжилдэг. Бучанитай нууж оруулсан утсаар удтал ярилцсан ноён Сарвестани “Хорих лагерьт тамлалтын хамгийн харгис хэрэглүүр нь цаг хугацаа өөрөө юм. Энд өнгөрүүлсэн урт, уйтгартай он жилүүд дүрвэгсдийн сэтгэл зүрхэнд хүнд шарх үлдээдэг” гэжээ.

Ираны өөр нэг дүрвэгч Манус дахь амьдралыг шог зургаар илэрхийлсэн байна. “Мөлжсөн загас” хэмээх нууц нэртэй энэ хүний бүтээл өнгөрсөн онд Олон улсын шог зураачдын эрхийн байгууллагаас Эр зоригийн шагнал хүртжээ. Түүний сэтгэцийн эрүүл мэнд доройтохын сацуу хоёрдугаар сард Манусын хэрцгий явдлыг эсэргүүцэн өлсгөлөн зарласан юм. Тэрбээр гурван долоо хоног өлсөн тэмцсэн агаад “Би дараа нь өвчин туссан. Одоо өвчин намдаагч мэтийн эмүүд ууж байгаа. Шог зураг л надад найдвар өгдөг” хэмээн өгүүлсэн байна.

Дүрвэгсдийн урлагийн төслийг үндэслэгч Сафдар Ахмед “Урлаг бол эдгээр хүмүүсийн хувьд амьд үлдэх боломж юм. Энэ нь сэтгэцийн эрүүл мэндээ хадгалахад тусалдаг. Урлагаас илүү тэдний зовлонг илэрхийлэх зүйл байхгүй” гэж ярих. Манус дахь Австралийн дүрвэгсдийн лагерийн амьдралын тухай баримтат жүжгийг Тегеранд үзүүлсэн байна. Энд Ираны Гадаад хэргийн дэд сайдаас гадна Австралийн дипломатууд байлцжээ. Жүжгийн зохиолч Назанин Сахамазадех “Би жүжгээ бичихийн тул тэнд хоригдсон арваад хүнтэй ярилцсан. Би жүжгээ Австрали болон бусад оронд тоглуулж, дүрвэгсдийн дуу хоолойг дэлхийд хүргэхийг хүсэж байна. Бас Манус, Науруд хаах хөдөлгөөн зохион байгуулна” гэжээ.

Австралийн Ерөнхий сайд Малколм Торнбулл аравдугаар сараас дээрх лагериудыг хаах асуудлыг хэлэлцжээ. АНУ-ын Ерөнхийлөгч асан Барак Обама Австралиас 1250 дүрвэгч авах тухай тохиролцсоны дагуу тэднийг Америк руу илгээж магадгүй. Гэвч шинэ Ерөнхийлөгч Трамп уг гэрээг “тэнэг” хэмээн шүүмжилсэн боловч АНУ-ын албаныхан Манусын дүрвэгсдийн байдлыг шалгасаар байгаа. Ноён Бучани “АНУ-тай байгуулсан гэрээнд маш олон тодорхойгүй зүйл бий. Бид юу бодохоо ч мэдэхгүй байна. Америкчууд надтай ярилцаагүй. Надад юу тогтоолдохыг бүү мэд” гэсэн билээ.



Эдийн засаг



Хүүхдээсээ харамлаж, өөрсдийгөө бордсон шийдвэр

Хүүхдийн мөнгийг хасаад хэмнэсэн мөнгө нь ердөө 50 тэрбум төгрөг

Хүүхдэд мөнгө өгөх замаар хүн амынхаа өсөлтийг дэмжих бодлого зөвхөн Монголд байдаг зохицуулалт биш л дээ. Дэлхийн олон улс үүнийг хэрэглэж, хөгжлийн сууриа тавьсан гэдэг. Ялангуяа Европын өндөр хөгжилтэй орнууд хүүхдийн мөнгийг хэрхэн хуваарилдаг тусгай хууль, дүрэмтэй. Тэр нь ямар ч үед хэрэгжиж л байдаг. Манай орны тухайд Ардчилсан нам 2004 оны сонгуульд өрсөлдөхдөө хүүхэд бүрт 10 мянган төгрөг өгнө гэж амласан нь тухайн үедээ л содон зүйл байлаа. Чухам энэ амлалт УИХ-д ганцхан суудалтай байсан тус намыг эрх барих хэмжээнд хүргэсэн гээд хэлчихэд буруудахгүй. Энэ үеэс хойш аль ч улс төрийн хүчин засгийн эрхэнд гарсан ч, хүүхдийн мөнгийг боомилж зүрхлээгүй. Хэрэв хүүхдийн мөнгөнд гараа дүрвэл олны эсэргүүцэлтэй тулгарч, намын нэр хүндээ алдаж, амлалтаасаа ухарна гэдгийг сайтар ойлгосон хэрэг.

Хоёр жилийн өмнө Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хүүхдийн мөнгийг зорилтот бүлгийнхэнд өгөх тухай санал гаргасан ч дэмжлэг хүлээгээгүй. Сөрөг хүчин байсан МАН тухайн үед хүүхдүүдийг ялгаварлан гадуурхлаа хэмээн шүүмжилж Ерөнхий сайдыг барьж идэх шахаж байсан. Ард түмэн ч тэдэнд талархалтай хандсан гэж жигтэйхэн.

Улмаар МАН сонгуульд өрсөлдөхдөө бүх хүүхдэд эрх тэгш олгоно гэж амласныг хэн ч мартаагүй. “Бид хүүхдүүдийг, олон хүүхэд төрүүлсэн ээжүүдийг, таны гэр бүлийг бүх талаар дэмжин хамгаалах болно” гэсэн гоё сайхан үгтэй мөрийн хөтөлбөр айл өрх бүрт тараагдсан гэдэгт итгэлтэй байна. Гэвч...

Ганцхан жилийн өмнө ард түмэндээ жигтэйхэн хайртай, тэдний төлөө юу ч хийхэд бэлэн байсан нөхөд эрх мэдэлтэй болонгуутаа ярьж, хэлж, тэмцэж байснаа мартана гэж хэн санах билээ. Худал амлахдаа үсчүүлсэн шүлс ч өдгөө хатаагүй л байна. Гэтэл долоон төрлийн татвар нэмж, зарим хэрэгцээгүй нийг-

мийн халамжийг багасгахаар төсөвт тодотгол хийсэн нь бүгдийн дургүйцлийг төрүүлсэн. Одоо ч олон нийт бухимдсан хэвээр. Тэд энэхүү шийдвэрээ ОУВС гэсэн үгээр зөвтгөөд өнгөрөх санаатай. Анх засгийн эрхэнд гармагц нийт хүүхдүүдийн 60 хувьд нь мөнгө олгоно. Үлдсэн 40 хувийнх нь мөнгийг 2019 онд бөөнд нь өгнө гэж хошигируулж байв. Гэтэл байр суурь нь дахиад л өөрчлөгдөж, “Мөнгө аваагүй хүүхдүүдэд нөхөж олгохгүй. Бас одоо авч буй 60 хувийг 40 хувь болгоно” хэмээн ард түмэн рүүгээ нулимлаа. Хэмнэсэн мөнгөө хоолны талон хэлбэрээр орлого багатай иргэдэд олгох юм гэсэн. Арай ОУВС ийм шаардлага тавиагүй л байлтай. Үнэхээр “Хүүхдийн мөнгөө хасаад оронд нь хоолны талон өг” гэж тулгасан бол их л хачин шаардлага тавьдаг сан бололтой.

Хэрэв өгч чадахгүй байсан бол яах гэж амласан юм гэж эрх баригчдаас асуумаар байна. Угаас улсын эдийн засаг хүндхэн байгаа гэдгийг мэдэхийн дээдээр мэдэж байсан шүү дээ. Анх сонгуульд өрсөлдөхдөө л төсөв санхүү хүнд, хүүхдийн мөнгө олгох боломжгүй гэж хэлээд гарч ирсэн бол ард түмэн арай өөрөөр хүлээж авах байв.

Хүүхдийн мөнгө хасаад хэмнэх мөнгө нь хэд гэдгийг та мэдэх үү. Ердөө 50 тэрбум төгрөг.

УИХ-д 65 суудалтай, өөрсдийгөө “хамгийн том, ууган хүчин” гэж нэрлэдэг нам энэ зэргийн мөнгийг зохицуулж, хүүхдүүдээ ялгаварлалгүй өгөхөд хүчин мөхөстсөн гэж үү. Ядаж амлалтаа хүрдэггүй юм гэхэд муу нэр зүүхгүйн тулд өөр эх үүсвэрээс хасаж танаад ч болов өгч болмоор. Гэвч Сангийн сайд нь ОУВС гэсэн ганц мэддэг үгээ тогь мэт давтаж, бүлгийн гишүүд нь морь унасан толгойгүй хүн мэт түүнийг нь дэмжив. Хувийн өмчийг ичих ч үгүй дээрэмдэж чадсан нөхдийн хувьд хүүхдийн мөнгөнөөс хулгайлах нь юу ч биш бололтой.

Айл өрхийн хэмжээнд авч үзвэл аав, ээж нь олсон хэдэн төгрөгөөрөө өөрсдийгөө зугаацуулж тансаглаад, хүүхдэдээ талх авч өгөх мөнгөө хасаж байгаатай зүйрлүүлж болмоор. Уг нь ямар ч эцэг, эх нэн түрүүнд хүүхдэдээ санаа тавьдаг. Гэвч зөвхөн өөрсдийгөө бодож, хүүхдийг хоёрдугаарт тавьжээ.

Үнэхээр эдийн засаг хэцүүдээд, улс тэр чигээрээ бүсээ чангалахаас аргагүйд хүрсэн бол ойлгож болохсон. Гэтэл үгүй юм аа. Нэг үйлдвэрийн дарга ажилд орсон даруйдаа 300 саяар өөртөө машин авч, 200 саяар байрандаа тавилга захиалсан баримт бэлээхэн байхад үүнийг нь буруушааж хориглосон албан тушаалтан нэг ч алга. Зөвхөн ганц дарга

хагас тэрбумаар ийн тансаглаж байхад улсын үйлдвэрийн бусад дарга нарын зардал нийлээд хэд болохыг таашгүй. Дарга нарын тансаг хэрэглээг харахад манай улс жигтэйхэн баян мэт. Харин хүүхдүүдээ алагчлан үзэж, 50 тэрбум төгрөг харамлаад байгааг нь бодохоор Африкийн зарим орон шиг үгээгүй ядуу болсон мэт.

ОУВС хүүхдийн мөнгийг заавал хасахыг тулгасан гэж бодохгүй байна

Манай улс 170 гаруй төрлийн халамж үзүүлж, үүнд нь дөрвөн хүн тутмын нэг нь хамрагддаг гэсэн тооцоо бий. Хэрэггүй халамжаа багасгах ёстой гэдэгтэй олон хүн санал нийлдэг. Гэхдээ хасч болохгүй халамж гэж бас бий. Үүний нэг бол хүүхдийн мөнгө. Цөөхөн монголчууд олуулаа болохыг дэмжих эдийн засгийн нэг чухал хөшүүрэг магадгүй энэ байх. Баячуудын хувьд хүүхдийн мөнгө онц шаардлагатай биш байж мэднэ.

Хэрэв тийм бол энэ мөнгөнөөсөө татгалзаж болно шүү дээ. Эсвэл

амьдрах гэж ядаж яваа А-гийнх шиг айлд буцалтгүй тусламж хэлбэрээр өгчихвөл их л зөв жишиг болно. Харин энэ мөнгийг амьдрал ахуйдаа нэмэрлэдэг, хүүхдийнхээ ирээдүйн сургалтын төлбөрт зориулж хадгалдаг айл ямар олон болохыг бодоод үзээрэй. Таны санаснаас их байх вий. ОУВС хүүхдийн мөнгийг заавал хасахыг тулгаж, дарамталсан гэж бодохгүй байна. Харин хэрэггүй зардлаа танах зөвлөмжийг нь мушгин гуйвуулж, хүүхдэд очих багахан мөнгийг дээрэмдэхээр ханцуй шамласан нь харамсалтай. Уг нь хүмүүс тэднийг иргэдээ дээрэмдэж, шулаатах гэж сонгоогүй л юмсан.

Ер нь аль ч засаг мөрийн хөтөлбөрөө бүрэн гүйцэд хэрэгжүүлж чаддаггүйг бид мэднэ. Тэгээд сонгууль дөхөхөөр “Арай амжсангүй. Дахиад дөрвөн жилийн хугацаа өгчих” гээд уйлан алдана. Гэхдээ ямар ч байсан хэрэгжүүлэхийн төлөө их, бага хэмжээгээр зүтгэсэн байдаг.

Харин одоогийн хэд шиг эрх авсан даруйдаа амласан мөрийн хөтөлбөрөөсөө 100 хувь эсрэг явж байгаа засгийг би лав мэдэхгүй юм. Дэлхийн улс төрийн түүхэнд байхгүй содон шийдвэр гэж үүнийг л хэлэх биз ээ. Улс төрийн мэдрэмжгүй, иргэдийнхээ амьдралын чанарыг дордуулсан энэ шийдвэрүүд чинь эргээд та бүхнийг гудамжинд гаргах вий. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» УУЛ УУРХАЙ

1.2 сая тонн
Монгол Улс жилдээ 1.1-1.2 сая тонн орчим газрын тос олборлож, экспортолж байна.

» ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

800 сая ам.доллар
“Оюутолгой” компани энэ онд 800 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ.

» ХАМТЫН АЖИЛЛАГАА
Санхүүгийн зохицуулах хороо Азийн хөгжлийн банктай хамтран санхүүгийн цахим үйлчилгээг сайжруулахаар болов.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ
“Ард Секюритиз” үнэт цаасны компанийн ашиг 2015 онд 73 сая төгрөг байсан бол 2016 онд 157 сая төгрөгт хүрч, хоёр дахин өссөн байна.

» МОНГОЛБАНК

163.7 сая ам.доллар
Төлбөрийн тэнцэл энэ оны гуравдугаар сарын байдлаар 163.7 сая ам.долларын алдагдалтай гарав.

» ХУДАЛДАА

68.7 хувь
Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 68.7 хувийг БНХАУ-тай хийсэн худалдаа эзэлж байна.

» ТАТВАР

27 тэрбум төгрөг
Импортын тамхины гаалийн албан татварын хэмжээг 30 хувь хүргэснээр төсвийн орлого ойролцоогоор 2017 онд 20, 2018 онд 26, 2019 онд 27 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

» ТӨЛӨВ

Монголбанк баасан гарагт ам.долларыг 2422.58 төгрөгөөр зарлалаа. Сар орчмын хугацаанд үргэлжилсэн ам.долларын ханшийн уналт өнгөрсөн долоо хоногт зогсож, эргэн өсөж тогтсон байна.

» ДЭЛХИЙ

62 ам.доллар
Ирэх жил олон улсын зах зээлд төмрийн хүдрийн ханш 50 ам.доллараас ч хямдарна гэж "Westpac Banking" байгууллагаас таамаглажээ. Энэ нь зах зээлд нийлүүлэлтийн илүүдэл үүсэхтэй холбоотой гэж үзэж байгаа аж. Шинжээчдийн тооцоогоор, төмрийн хүдрийн ханш гуравдугаар улиралд тонн тутамдаа 62 ам.доллар болохоор байна.

» САНХҮҮГИЙН ТОЛЬ
Ипотекийн зээлийн банк-Mortgage bank-Ипотекийн зээлийг олгох, зарах, үүний үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй банк, санхүүгийн байгууллага.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ доллар	2422.41
Евро	2629.89
Япон иен	22.01
ОХУ рубль	43.23
БНХАУ юань	351.77
БНСУ вон	2.14



Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Түншлэлийн хэлэлцээрийн үр ашгийг төдийлэн сайн гаргаж чадахгүй байна

Японоос өндөр технологи импортлох нь эдийн засгийг тогтвортой өсгөх хөшүүрэг

Б.Мөнх
ЗГМ

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга М.Оюунчимэстэй ярилцлаа.

-Япон улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг манай улсын дотоодын аж ахуйн нэгж хэр үр дүнтэй ашиглаж байна вэ. Өнгөрсөн хугацаанд хэлэлцээр хангалттай өгөөж авчирсан уу?

-Монголын түүхэнд анхны гэж хэлж болох эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг Япон улстай байгуулсан нь онцлох үйл явдал байсан. Уг хэлэлцээр нь өнгөрсөн оны хоёрдугаар хагаст хүчин төгөлдөр болж, албан ёсоор хэрэгжиж байна. Хэлэлцээрийг бэлтгэх ажилд манай танхим хувийн хэвшлээ төлөөлж идэвхтэй ажиллаж ирлээ. Энэ хүрээнд төрийн байгууллагатай нягт хамтарч ажилласан. Монголын гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүнийг Японы зах зээлд гаргах, улмаар таниулахад танхимын зүгээс ихээхэн ач холбогдол өгч байна. Манай улсаас Японы зах зээлд экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүний жагсаалтаас харахад боломж их байгаа боловч тэр хэмжээнд одоогоор олон нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн экспортолж чадахгүй байна. Үйлдвэрлэлийн хэмжээ, экспортод гаргаж байгаа бараа,



Б.Ганбаяр / ЗГМӨ

бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар энэ байдалд нөлөөлж байна.

-Таны үзэж байгаагаар түншлэлийн хэлэлцээрийн үр ашгийг төдийлэн гаргаж чадахгүй байх шиг байна. Хоёр улсын худалдаанд ямар төрлийн бараа, бүтээгдэхүүн жин дарж байна вэ?

-Экспорт, импортын тоог аваад үзвэл Японоос оруулж ирж байгаа нийт барааны 90 хувь нь автомашин. Үлдсэн хувь нь цөөн нэр төрлийн өөр бараа бүтээгдэхүүн байна. Энэ нь нийт худалдаанд 10 хувиас хэтрэхгүй байгаа. Бид Японы зах зээлээс зөвхөн шинэ болон хуучин

автомашиныг нь авч байна. Худалдааны харилцааг тэлэх, төрөлжүүлэх хэрэгцээ, шаардлага их байна. Ялангуяа, хэлэлцээрийг ашиглаж илүү өндөр технологи оруулж ирэх нь чухал. Өндөр технологи үнэтэй. Гэхдээ үүнийгээ дагаад өгөөж нь илүү байдаг. Үнэ, өртөг их ч бүтээмж дээшилж, үр дүн нь тодорхой хугацаанд гарах учраас өөрсдийн түүхий эдээ боловсруулах, нэмүү өртөг шингээх үүднээс өндөр технологи оруулж ирэх өргөн боломж бий.

-Түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд манай улс 5700 орчим нэр төрлийн бараа,

бүтээгдэхүүн дээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх ёстой. Одоогоор хэчнээн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн Японы зах зээлд гаргаж байна вэ?

-Хоёр талын байгуулсан хэлэлцээрийн хүрээнд олон нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн татварын дэмжлэг авахаар байна. Манай компаниуд экспортод одоогоор 10-аадхан нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаж байгаа. Үүгээр нэр төрөл нь хязгаарлагдаж байна. Тухайлбал, ноос, ноолууран бүтээгдэхүүн үүний дийлэнх хувийг нь эзэлж байх жишээтэй. Манайх ноос, ноолууран бүтээгдэхүүнээс гадна гар урлалын бүтээгдэхүүн болон уул уурхайн зарим нэг төрлийн бүтээгдэхүүн экспортолж байна. Энэ нь түншлэлийн хэлэлцээр байгуулчихсан орны хувьд чамлах үзүүлэлт. Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өнгөрсөн хугацаанд 350 гаруй гарал үүслийн гэрчилгээг дотоодын аж ахуйн нэгжид олгосон. Өөрөөр хэлбэл, 350 нэр төрлийн бүтээгдэхүүн Японы зах зээлд хүрсэн байна. Татварын хөнгөлөлтийг гарал үүслийн гэрчилгээний үндсэн дээр эдэлж байгаа. Гарал үүслийн гэрчилгээ нь тухайн бараа бүтээгдэхүүн бүхэлдээ болон хэсэгчлэн Монгол Улсад үйлдвэрлэсэн болохыг албан ёсоор баталгаажуулсан үнэт цаас юм.

-Японоос гадна Европын холбооны хэчнээн оронд манайх бараа, бүтээгдэхүүн гаргахад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр байгаа вэ?

-Тарифын хөнгөлөлтийн ерөнхий системийг хэрэгжүүлэх Европын холбооны 28 оронд 7200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр байгаа. Энэхүү боломжийг манай

дотоодын үйлдвэрлэгчид ашиглах нь тааруухан. Харамсалтай нь одоо Европын холбооны орнуудад экспортолж байгаа бараа, бүтээгдэхүүний нэр төрөл бас л бага хэвээр байна. 7200 нэр төрлийг харах юм бол Монголд өнөөдөр үйлдвэрлэх нь байтугай, мэдэхгүй ч тийм бараа, бүтээгдэхүүн жагсаалтад бий. Энэ нь нөгөө талаасаа хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах маш том суурь гэж үзэж байгаа. Бид давуу талаа хөрөнгө оруулагчдад сайтар таниулах хэрэгтэй. Хөнгөлөлтийн систем, татварын таатай нөхцөлөө бүрэн дүүрэн биш юм гэхэд өөрсдийн боломжоор ашиглах учиртай.

Манай компаниуд 10-аадхан нэр төрлийн бүтээгдэхүүн гаргаж байна

-Арбитрын тухай хуулийн ач холбогдлыг хэрхэн үнэлж байгаа вэ?


-Арбитрын тухай хуулийг баталсан нь бизнес эрхлэгчдэд томоохон боломж нээж өгсөн. Учир нь Арбитрын тухай хууль гэж гарснаар бизнесийн орчинд тулгардаг маргааныг цаг алдахгүй шийдвэрлэх нөхцөл бүрдэж байна. Хуулийн тухайд гэвэл олон улсын стандартад нийцсэн, аль ч орны арбитр хүлээн зөвшөөрөх хууль болсон гэж үзэж байгаа. Монголд хөрөнгө оруулагчидтай үүссэн маргааныг зөвхөн Лондоны арбитр гэлгүй бусад орны маргаан шийдвэрлэх арбитр оролцох бус Монголдоо шийдвэрлэх эрх зүйн орчин улам баталгаажиж байна. Үүнийг дагаад дотоодын Арбитрын байгууллагын нэр хүнд өсөж,

олон улсын байгууллагаас арбитрчдын ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох, сургалт авах зэрэг боломж бий болж байна. Арбитрын шугамаар маргаанаа шийдвэрлэх нь урьд жилүүдтэй харьцуулахад өсөж байгаа. Бизнес эрхлэгч нар Арбитрын ач холбогдлыг маш сайн ойлгодог болсон байна. Арбитраас гадна манай танхим эвлэрүүлэн зуучлах үйлчилгээг Монголд анх удаа бий болгож, хэрэгжүүлсэн. Энэ нь маргалдаж байгаа хоёр талыг илүү хурдан шийдэлд хүргэж, асуудлаа бүрэн дүүрэн ойлгож, эвийн журмаар шийдвэрлэхэд туслах зорилготой юм.

-Бизнесийн орчны нөхцөл байдлыг та хэрхэн харж байна вэ?

-Бизнесийн орчин өнгөрсөн хугацаанд тийм ч таатай байсангүй. Улс төрийн нөхцөл байдлаас үүдэж ойлгомжгүй, тодорхой бус байдал бизнесийн орчинд үүссэн. Төрөөс гаргаж буй шийдвэр тогтворгүй, хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээний орчинд итгэл суларсан нь олон гаднын компанийг хүлээлтийн байдалд орууллаа. Тэрчлэн уул уурхайн түүхий эдийн үнэ дэлхийн зах зээлд хэлбэлзэлтэй, үнэ уруудсан учраас манай улсын экспорт төдийлэн сайн байсангүй. Нөхцөл байдлаа харгалзан үзэж, зөв менежмент явуулах, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой бодлого дутагдаж байлаа. Эдийн засагт илүү сайн нөлөө үзүүлэх мега төслүүдээ цаг алдалгүй эдийн засгийн эргэлтэд оруулах хэрэгтэй. Том төслийг дагаж бусад бизнес хөгждөг. Бүх зүйл эргэх холбоотой. Тиймээс төр хувийн хэвшилд бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг олгох нь чухал байна. [ЗГМ]

Хөрөнгийн биржийн индекс 0.39 хувиар буурав



MSE ALL

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД						
НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	59.82	▼ -0.7%	4/24/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.048	▲ +37.14%	4/24/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	26.25	▼ -0.47%	4/24/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.022	▼ -4.55%	4/24/2017
GUILD FORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	4/24/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.55	▲ +0.28%	4/24/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.61	▼ -0.82%	4/24/2017
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.315	▼ -22.22%	4/24/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.2	▼ -4.76%	4/24/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.61	▲ +3.39%	4/24/2017

ТҮҮХИЙ ЭД					
НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1271.82	▼ -0.98%	4/24/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	970.3	▼ -0.75%	4/24/2017
МӨНГӨ	SIA	унци	17.87	▼ -0.37%	4/24/2017
ЗЭС (КОМЕХ)	HGA	фунт	257	▲ +0.74%	4/24/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	70	▼ -1.31%	4/24/2017
WTI TOC	CLA	баррель	49.8	▲ +0.36%	4/24/2017
БРЕНТ	COA	баррель	52.15	▲ +0.37%	4/24/2017
БЕНЗИН	XBA		164.97	▲ +0.32%	4/24/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.119	▲ +0.58%	4/24/2017
НҮҮРС (NYMEX)	OZA	тонн	336.55	▲ +0.21%	4/24/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	79.1	▼ -0.06%	4/24/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	16.51	▲ +0.61%	4/24/2017
БУДАА	RRA	центнер	9.74	▼ -0.31%	4/24/2017
БУУДАЙ	WA	бушель	424	▲ +0.71%	4/24/2017
КАКАО	CCA	тонн	1850	▲ +2.83%	4/24/2017
КОФЕ	KCA	фунт	132.9	▼ -1.04%	4/24/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул

үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ					
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО	
АПУ ХК	APU	330	▲ 3.11%	4/24/2017	
ГОВЬ ХК	GOV	13600	▼ -2.23%	4/24/2017	
МАХ ИМПЕКС ХК	MMX	2400	◄► 0%	4/24/2017	
СҮҮ ХК	SUU	130	▲ 0.78%	4/24/2017	
АДУУН ЧУЛУУН ХК	ADL	2414	▼ -13.82%	4/24/2017	
БАГАНУУР ХК	BAN	1961	▲ 6.52%	4/24/2017	
БИ ДИ СЕК ХК	BDS	1200	▼ -11.11%	4/24/2017	
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	ETR	98	▼ -1.01%	4/24/2017	
ЖЕНО ТУР БЮРА ХК	JTB	56	◄► 0%	4/24/2017	
МАТЕРИАЛ ИМПЕКС ХК	MIE	8255	◄► 0%	4/24/2017	
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	382	▼ -0.05%	4/24/2017	
РЕМИКОН ХК	RMC	45.91	▲ 1.82%	4/24/2017	
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	5240	▼ -2.33%	4/24/2017	
ТҮШИГ УУЛ ХК	TUS	310	◄► 0%	4/24/2017	
СТАНДАРТ НООС ХК	ALI	625	◄► 0%	4/24/2017	
БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	BHL	580	▼ -1.69%	4/24/2017	

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД					
НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5910.521	-6.26	▼ -0.11%	4/24/2017
DAX INDEX	DAX	12331.11	+282.54	▲ +2.35%	4/24/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15614.48	-11.08	▼ -0.07%	4/24/2017
S&P/ASX 200	AS51	5871.783	+17.65	▲ +0.3%	4/24/2017
S&P 500	INX	2348.69	-7.15	▼ -0.3%	4/24/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3129.531	-43.62	▼ -1.37%	4/24/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	20547.76	-30.95	▼ -0.15%	4/24/2017
TOP 20	MSETOP	13056.8	-30.44	▼ -0.23%	4/24/2017
FTSE 100	UKX	7216.89	+102.34	▲ +1.44%	4/24/2017
HANG SENG	HSI	24147.03	+105.01	▲ +0.44%	4/24/2017
NIKKEI 225	NKY	18875.88	+255.13	▲ +1.37%	4/24/2017